

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.04.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **Төлөөлөгчид** 3 дугаар сард 1 удаа хуралдаж, 5 асуудал хэлэлцэн хэлэлцлээ. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг хэлэлцээд “Хангалттай” гэж үнэллээ.

2.Зарим газрыг бичил уурхайн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг хэлэлцээд “Аймгийн тусгай хэрэгцээний газрын зориулалт, хэмжээг өөрчлөн тогтоох тухай” болгон өөрчилж Байгалийн үзэсгэлэнт газрыг хамгаалах зорилгоор аймгийн тусгай хэрэгцээнд авсан 16642,04 га газраас Ерөө сумын Өлөнт, Цамхаг, Могойн гол нэртэй газрын 19,04 га газрын зориулалтыг өөрчилж бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч 16623 га болгон өөрчлөн тогтоолоо. Дээрх тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын 2018 оны 44 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсон.

3.Сэлэнгэ аймгийг Хөдөлмөрийн баатар цолоор шагнуулахаар санал уламжлах тухай асуудлыг хэлэлцээд төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжиж, Сэлэнгэ аймгийн 2019 оны төсөв батлах тухай 51 дүгээр тогтоолын хавсралт дахь зарим төсөл, арга хэмжээний нэршил өөрчлөх тухай асуудлыг хэлэлцээд уг тогтоолын хоёрдугаар хавсралтад “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын 1.2.1, 1.2.9, 1.3.8 дахь арга хэмжээний нэршлийг өөрчлөн тогтоолоо. Мөн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны ажлын тайланг хэлэлцээд “Хангалттай” гэж дүгнэлээ.

Аймгийн ИТХ-ын **Тэргүүлэгчид** 2 удаа хуралдаж, 11 асуудлыг хэлэлцэн 11 тогтоолыг баталлаа. Үүнд:

1.Аймгийн ИТХ-ын XIV хуралдааныг товлон хуралдуулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын ээлжит хуралдааныг 2019 оны 03-р сарын 28-ны өдөр аймгийн төвд товлон хуралдуулахаар товыг тогтоолоо.

2.Хүн ардынхаа эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ж.Одыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнав.

3.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийн ой хээрийг гал түймрээс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн батлав.

4.“Сэлэнгэ Баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын тайланг сонсоод холбогдох шийдвэрийг гаргав.

5.Алдарт эхийн I, II одонгоор шагнуулах зарим эхчүүдийн материалыг МУ-ын Ерөнхийлөгчид уламжлан хүргүүлэхээр тогтлоо. Үүнд: Алдарт эхийн I одонгоор 38, Алдарт эхийн II одонгоор 297 хүнийг шагнуулахаар тодорхойлов.

6.Олон улсын Шатрын спортын мастер А.Энхтуулын гавьяа зүтгэлийг үнэлж Гавьяат тамирчин цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав.

7.Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим иргэдийн төрийн одон медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав. Үүнд: Алтан гадас одонгоор 5, Хөдөлмөрийн хүндэт медалиар 13 хүнийг уламжиллаа.

8.Дулаанхаан тосгоны Эрүүл мэндийн төвийн 60 жилийн ойг 2019 оны 8 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрлийг олгов.

9.Сант сумын Эрүүл мэндийн төвийн 90 жилийн ойг 2019 оны 7 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрөл олгов.

10.Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 60 жилийн ойг 2019 оны 8 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтоов.

11.Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй Христийн шашны “Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн Сүхбаатар цуглаан”-ы үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгалаа.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа М.Энх-Амар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ж.Сауле, Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Ц.Батбаяр нараар ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймагт 2 өдөр ажиллалаа. Энэ үеэр 2019 оны мал хаваржилт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар зохион байгуулж буй ажил, цаашид авч хэрэгжүүлэх асуудлын талаар холбогдох газраас танилцуулсан бөгөөд хаваржилт болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр үүрэг даалгаврыг өгсөн.

Монгол Улс, БНХАУ хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд тус Улсын Хар мөрөн мужийн Гадаад харилцааны дэд даргаар ахлуулсан төлөөлөгчид энэ сарын 22-23-ны өдрүүдэд тус аймагт ажиллаж, аймгийн Засаг дарга болон аймгийн удирдлагын багтай уулзаж, хамтын ажиллагаа, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар харилцан санал солилцож 2014 онд байгуулсан “Санамж бичиг”-ийг үргэлжүүлэх болон бусад салбарт хамтран ажиллах талаар харилцан тохиролцлоо.

Аймгийн “Малчдын зөвлөгөөн”-ийг 3 дугаар сарын 29-нд зохион байгуулж, тариалангийн бүс нутагт тохирсон эрчимжсэн болон хагас суурин мал аж ахуйг хөгжүүлэх, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгч, малчдын саналыг сонслоо.

2019 онд нийт 724889 эх мал төллөхөөс 3 дугаар сарын 25-ны байдлаар нийт 90667 мал төллөж үүнээс Ингэ 11, гүү 421, үнээ 3653, эм хонь 49623, эм ямаа 37013 төллөсөн байна. Үүнээс Ботго 11, унага 418, тугал 3645, хурга 49607, ишиг 36986 төллөсөн бойжилтын хувь 99.9% байна. Том малын зүй бус хорогдол нийт 715 үүнээс адуу 60, үхэр 157, хонь 266, ямаа 232 үүнээс хээлтэгч мал нийт 174 үүнээс гүү 5, үнээ 48, эм хонь 76, эм ямаа 45 зүй бусаар хорогдсон байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргил Ерөө суманд ажиллаж, иргэлтэй уулзалт хийж, тус сумын ирээдүй болсон хүүхэд багачууд, эцэг эхчүүдийн эрх ашгийн үүднээс 100 хүүхдийн цэцэрлэгийн асуудлыг шийдвэрлэхээр боллоо. Тус сумын одоогийн цэцэрлэгийн барилга нь цууралт үүсч, ан цав гаран, суултад орж, МХГ-аас сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулахгүй байх шийдвэрийг гаргасан. Мөн тус сумын төр төсвийн байгууллагуудыг нэгдсэн халаалттай болгох инженерийн шугамын төсвийг 2020 оны төсөвт суулгахаар боллоо. Мөн 3-р сарын 6-ны өдөр аймгийн Засаг дарга аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ дэмжсэн ажил, арга хэмжээний талаар холбогдох хүмүүсийн саналыг авч харилцан ярилцлаа. Уулзалтад аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, мэргэжилтэн, аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны төлөөлөл оролцсон бөгөөд аймгийн даргын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хардаг эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ чөлөөт цагийг өнгөрөөх газрыг бий болгох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ өөрсдийн гэсэн байртай болгохоор зорьж байгаа талаараа танилцуулж, инженерийн шугамд ойр газрыг олж, зураг төслийг гаргахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт үүрэг болголоо.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газрын 2018 оны хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайланг, хавсралт тайлангуудын хамт боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүллээ.

Аймгийн ИТХ-ын 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3-р сарын 25-нд болсон аймгийн ИТХ-ын ээлжит 14-р хуралдаанаар Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайлан, зарим газрыг бичил уурхайн зориулалтаар аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай, аймгийн тусгай хэрэгцээний газрын зориулалт, хэмжээг өөрчлөн тогтоох тухай, Сэлэнгэ аймгийг Монгол Улсын төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулахаар санал уламжлах тухай болон Сэлэнгэ аймгийн 2019 оны төсөв батлах тухай 51 дүгээр тогтоолын хавсралт дахь зарим төсөл, арга хэмжээний нэршил өөрчлөх тухай асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүллээ. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийн ой хээрийг гал түймрээс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, “Сэлэнгэ Баялаг ирээдүй” ОНӨААТҮГ-ын тайланг тус тус хэлэлцүүллээ.

Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга (ЭТИС) хөтөлбөрөөс аймгийн ЗДТГ-тай хамтран “Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын тусгай сан”-г байгуулж, 30000 еврогийн буюу 88,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх гэрээг байгуулсан. Энэ сангаас аймагт бүртгэлтэй аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, бүлэг нөхөрлөл, аж ахуйн нэгжийн дунд 2019 оны 1 дүгээр сарын 22-ноос 2 дугаар сарын 28 хүртэлх хугацаанд төслийн уралдааныг зарлаж, нийт 12 төслийг хүлээн авч, төслийн сонгон шалгаруулалтыг тус хөтөлбөрөөс гаргасан журмын дагуу 3-р сарын 19, 20-ны хооронд 2 үе шаттай зохион байгууллаа. Төслийн уралдаанд оролцсон бүх оролцогчдод 350000 төгрөгийн “Төсөл маркетингийн зөв бичиж, хэрэгжүүлэх” сэдэвт сургалтад суух эрхийн бичгээр урамшуулж, Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Баруунбүрэн, Мандал сумдын жуулчны бааз, амралт, сувиллын газар, нөхөрлөлүүдэд нэн тулгамдсан эко бие засах газар болон бусад асуудлыг шийдвэрлэхээр боллоо.

УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын санаачилгаар ЕБС-ийн төгсөх ангийн сурагчид, эцэг эхчүүдэд зориулсан “Мэргэжил сонголт” арга хэмжээг 2009 хойш тасралтгүй 10 дахь жилдээ зохион байгуулж байна. “Мэргэжил сонголт-2019” арга хэмжээг аймгийн төв Сүхбаатар суманд 3-р сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд 33 сургуулийн удирдлага, багш нар, нийт 405 сурагч, эцэг эхчүүд бөгөөд БСШУСЯ, харьяа байгууллагууд, дэлхийн түвшинд Монголдоо хүлээн зөвшөөрөгдсөн шилдгийн шилдэг 10 их сургуулийн удирдлага, нэртэй багш нарыг урьж, нэг дороос “Мэргэжлээ сонгох”, Монголын болон дэлхийн томоохон их, дээд сургуулиудад тэтгэлгээр суралцах боломжийн талаарх мэдээлэл, сургамж, зөвлөгөөг өглөө. БСШУСЯ-ны Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн мэргэжилтэн, БСШУСЯ-ны Боловсролын зээлийн сангийн мэргэжилтэн, Улаанбаатар хот дахь ОХУ-ын Шинжлэх ухаан, соёлын төвийн ахлах референ, Монгол-Германы Ашигт малтмал, технологийн их сургуулийн Олон нийттэй харилцах мэргэжилтэн, Маркетингийн ажилтан, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Сургалтын албаны дарга, Монгол Улсын Их сургуулийн Оюутны элсэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Аюулгүй байдлын сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга, Ахисан түвшний сургалтын албаны дарга, Ахисан түвшний сургалтын албаны докторын хөтөлбөр, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн их сургуулийн Агро экологийн сургуулийн сургалт эрхэлсэн орлогч захирал, Хууль сахиулах их сургуулийн Сургалтын чанарын албаны ахлах мэргэжилтэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Оюутны албаны арга зүйч, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Оюутны хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Соёл урлагийн их сургуулийн Оюутны хөгжил төвийн эрхлэгч, Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн Сургалтын албаны мэргэжилтэн багш нар мэдээлэл өглөө.

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд оруулсан мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчийн цалин бодогдохоор болсон тухай мэдээллийг төрийн байгууллагын төсвийн шууд захирагчи нар болон хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд цахим сургалтыг зохион байгуулж, системийн мэдээллийг сар бүр оруулахаар болсон бөгөөд мэдээллийг тухай бүр тогтмол шинэчлэх, албан хаагчдын үндсэн цалин болон сар бүр

тогтмол авч буй нэмэгдлийг байгууллагын санхүү хариуцсан ажилтнаар хянуулж мэдээллийг үнэн зөв оруулах, 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар шинэчилснээс хойших мэдээллийг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө системд шинэчилж, хүний нөөцийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөлт, албан хаагчдын анкетийн баяжилтуудыг тогтмол хийж хэвших, системд мэдээллээ шинэчлээгүй, үнэн зөв оруулаагүйгээс үүдэн тухайн байгууллагын албан хаагчдын цалин буруу бодогдох магадлалтайг анхааруулж, үүнээс үүдэн гарах хариуцлагыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч бүрэн хариуцах талаар дэлгэрэнгүй мэдээллийг өглөө.

Мөн аймгийн Засаг даргын урилгаар Худалдаа үйлдвэрлэлийн бакалавр, Төрийн удирдлагын мастер, сургагч багш Б.Батцэцэг “Эерэг сэтгэлгээ хандлагын боловсрол” сэдэвт лекцийг Сүхбаатар сум дахь төр төсвийн байгууллагын төрийн албан хаагчдад тавьж, төрийн албан хаагчид ажил албандаа, ар гэр ахуй амьдралдаа хэрхэн хандах хандлагын талаар уг лекцээс сонслоо.

Монгол улсын Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын дагуу Гамшгийн үед зарлан мэдээллийн дохиогоор нэгэн зэрэг ажиллах сургалтыг жил бүрийн 3 дугаар сарын гурав дахь долоо хоногийн пүрэв гарагт Улс орон даяар гамшиг, ослын дуут дохиог ажиллуулж, гамшгийн үеийн бэлтгэл сургуулилт хийдэг. Энэ жил уг өдөр 3-р сарын 21-нд болж, 16:00 цагт улс даяар нэгэн зэрэг зохион явууллаа.

“Монгол Цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн хүрээнд Сүхбаатар цэргийн хотхоны анги, байгууллагуудын алба хаагчдын дунд “Цэрэг-спорт”-ын олон төрөлт тэмцээнүүдийг 3-р сарын 06-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тэмцээнд аймагт үйл ажиллагааг явуулж буй Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагч нар идэвх санаачлагтай байж, хур хүч, авхаалж самбайгаа оролцлоо. Тэмцээний нэгдсэн дүнгээр хилийн 0243 дугаар анги анги Тэргүүн байр, дэд байранд Онцгой байдлын газар, гутгаар байранд Хилийн 0101 дүгээр анги эзэллээ. Мөн тус аймгаас цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 336 дугаар ангид алба хааж байгаа дайчдыг эргэх ажлыг 3 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулж, арга хэмжээнд аймгийн засаг даргын орлогч, Цэргийн штабын дарга, офицерууд болон цэргийн албан хаагчдын ар гэрийн төлөөлөлүүд оролцсон.

Мэргэжлийн хяналтын газрын ажил үйлчилгээний талаар

2019 оны төлөвлөгөөт хяналт шалгалтыг 8 суманд 76, зөвлөн туслах үйлчилгээг 34, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 12 объектод хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлж, 3 аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг зөрчил дутагдлаа арилгах хүртэл хугацаагаар зогсоож, хэрэгжилтэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 3 иргэнд 150000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. МХЕГ-ын дэд даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны хавар тариалах таримал ургамлын үрийн хадгалалт, нөөцлөлтийн байдал, чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шинжилгээт хяналт шалгалтыг 11 сумын 39 аж ахуй нэгж, иргэдийн 6400 тонн улаанбуудайн болон үр тариа төмсний үрийн дээжинд итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, чанар аюулгүй байдлыг нь тодорхойлох арга хэмжээг авлаа. Мөн газраас ирүүлсэн “Ашигт малтмалын хууль бус олборлолтоос урьдчилан сэргийлэх тухай удирдамж, иргэнээс ирүүлсэн мэдээллийг үндэслэн аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын байгууллагатай хамтран Ерөө сумын 3 дугаар багийн нутаг Бугант тосгоны Улаан хясаа гэх газарт эрхэлсэн тодорхой ажилгүй нэр бүхий иргэд Ерөө голын гольдрил дотор мөс цөмлөн хууль бусаар алт олборлож байсан зөрчлийг илрүүлэн Цагдаагийн байгууллага шалгаж байна. Энэ үеэр Хүдэр сум, Бугант тосгоноос Улаанбаатар хот болон бусад суурин газар руу тээвэрлэж байгаа мод, модон материалын тээвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийж Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн 3 аж ахуйн нэгжид холбогдох зөрчлийг илрүүлж Зөрчлийн тухай хуулийн дагуу 4.000.0000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг тооцон барагдуулж, 4 метрийн урттай 100 ш 15*15 харьцаатай нарсан дүнг /палк/ улсын орлогод хураасан.

Цаг агаарын огцом дулааралттай холбоотой үер усны аюул осол, мал, амьтны халдварт өвчний эрсдлээс сэргийлэх зорилгоор Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө зэрэг томоохон гол, мөрөн, голын сав дагуу нутаглаж байгаа иргэд, малчид голоор гарахдаа зориулалтын гүүр ашиглах, тогтсон гарамгаар болгоомжтой гарах, шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар иргэд, аж ахуйн нэгж, олон нийтэд анхааруулах, үерийн хамгаалалтын далангуудын өнөөгийн байдлыг шалгаж аюулгүй байдлыг хангуулах, мөн хорогдсон мал амьтны сэг, зэмийг ариутгал, халдваргүйтгэл хийн дарж булшлан халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай сэрэмжлүүлгийг сумдад хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Тайлант сард 11 зөрчлийн хэргийг нээж хуулийн хугацаанд аймгийн прокурорын хяналтан дор бүрэн шийдвэрлэж, итгэмжлэгдсэн лабораториос 50 аж ахуйн нэгжийн 160 дээжинд 920 үзүүлэлтээр шинжилгээ хийж, 24 аж ахуйн нэгжийн 44 дээж 55 үзүүлэлтээр эерэг гарсан байна.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар

Олон Улсын “Хэрэглэгчийн өдөр”-ийг тохиолдуулан 3-р сарын 15-ны өдөр аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл, Сүхбаатар сумын ЗДТГ-тай хамтран Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд, мэдээлэл хийж, уулзалт зохион байгуулав. Тус хэлтсийн баталгаажуулалтын ахлах шинжээч Л.Анхцэцэг “Худалдааны газар, түүний үйлчилгээ. Үндсэн шаардлага MNS 5021:2007” стандартаар мэдээлэл өгч, иргэдэд гарын авлага тарааж, “Архигүй Сэлэнгэ” аяны хүрээнд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэстэй хамтран согтууруулах ундаа худалдан борлуулдаг 7 хүнсний дэлгүүр, 1 худалдааны агуулах, 2 минимаркет, 4 зоогийн газар, 3 баарны үйлчилгээнд хяналт шалгалт хийж, тохирлын гэрчилгээний хугацаа дууссан 5 үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж гэрчилгээ олголоо.

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Мандал, Баянгол, Сайхан сумын 11 аж ахуйн нэгж, иргэний 1 хүнсний мухлаг, 1 цайны газар, 2 хүнсний дэлгүүр, 2 минимаркет, 4 караоке баар, 2 зоогийн газар, 1 зочид буудал, 1 авто машины сэлбэгийн худалдаа гэсэн нийт 14 үйлчилгээнд МУ-ын “Худалдааны газар, түүний үйлчилгээ үндсэн шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага MNS 4946:2005”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Зочид буудалд тавих шаардлага MNS 4588:2008”, “Авто үйлчилгээ, ангилал. Ерөнхий шаардлага MNS 5025:2001 стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгож, Шаамар сумын иргэн Д.Мягмарын ирүүлсэн зөгийн бал, Сайхан сумын иргэн И.Эрдэнэтуяагийн үйлдвэрлэсэн луувангийн салат, кимчи, бууцай, хүрэн манжин, луувангаар баяжуулж хийсэн хэрчсэн гурил, Мандал сумын “Уулын нуур” ХХК-ий үйлдвэрлэсэн 7 төрлийн нарийн боов, 1 талх гэсэн 14 бүтээгдэхүүнийг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит шинжлүүлж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өгч арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Стандартын салбар сангаас 13 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 10 нэрийн 16 стандартаар хангаж, аргазүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс 8 аж ахуй нэгж байгууллагад 5 нэрийн 9 стандартын борлуулалт хийж, иргэн, үйлчлүүлэгчдийн хүсэлт, захиалгын дагуу шаардлагатай стандартын талаарх мэдээллийг өгч, арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр Төмөртэйн уурхайн шатахуун түгээх станцын 1 түгээгүүрт, 6 байгууллагын 8 усны тоолуурыг шалган баталгаажуулалтын гэрчилгээ олголоо. Мөн 3 байгууллагын шатахуун хэмжих 3 мерник, 2 сүмбэнметр, Зүүнбүрэн сумын мал эмнэлгийн лабораторит ашиглах 5 шилэн хэмжүүрт, Сүхбаатар Зүтгүүрийн Делогийн шатахууны 17 нөөцлөх саванд онооллын хүснэгт зохион шалгалт тохируулга хийж, Механикийн төрлөөр ээлжит баталгаажуулалтыг Сүхбаатар сумын худалдааны газруудын 32 жин 6 туухай шалган баталгаажуулж, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн лабораторийн 1 электрон жинд шалгалт тохируулга хийлээ.

Ерөө, Хүдэр сум, Бугант тосгоны байгууллага нэгжийн 21 ш цахилгааны 3 фазын тоолуурт ДСЦТС-ын лабораторитой хамтран баталгаажуулалт хийж, өөрийн лабораторит 5 нэг фазын тоолуурыг шалган баталгаажуулж, “Эм Импекс” ХХК-ий 1 цусны даралтын аппаратыг ээлжит баталгаажуулалтанд хамруулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

2019 оны 2 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулаад байна. Аймгийн төсвийн гүйцэтгэлийн 2-р сарын мэдээгээр орон нутгийн төсвийн нийт орлого 3,2 тэрбум буюу 124,2 хувь, төсвийн зарлагын гүйцэтгэл 11,1 тэрбум буюу 77,1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 оны жилийн эцсийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулан 2018 онд олгосон санхүүжилтийн дэмжлэг, ОНХС-ийн шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн тооцоог сум, байгууллагаар нь гарган холбогдох газруудтай тооцоог хийж, сумдын төсвийн захирагчдын болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын тайланг хүлээн авч байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын 2019 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайлан тушаалт 3-р сарын 31-ны байдлаар 80,9 хувьтай байна.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		11259371.1	11759571.2	104.4
1.1	Орон нутгийн төсвийн орлого	2.616.755.8	3.249.759.9	124.2
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	1.865.339.8	2.582.150.5	138.4
	Сумдын төсвийн орлого	751.416.0	667.609.4	88.8
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1.098.428.7	1.098.428.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	7.155.326.6	7.155.326.6	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	388.260.0	256.056.0	65.9
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	600.0		
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/			
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого /сум хөгжүүлэх сан орсон/			
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		14.418.639.1	11.116.819.6	77.1
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	14.418.639.1	11.116.819.6	77.1
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	6.711.177.1	5.733.572.7	85.4
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан			
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	2.633.310.7	1.903.835.6	72.2
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	70.000.0		
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт			
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	364.683.0		
	Халамжийн сан	16.800.0	9.600.0	57.1
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	2.072.927.7	1.065.062.1	51.4
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	108.900.0	92.420.3	84.9
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	8.671.098.0	7.094.458.2	81.8
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	149.423.0	131.277.8	87.9
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		4.968.065.1	4.968.065.1	100.0

3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1.394.363.4	1.394.363.4	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	23.577.0	23.577.0	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	23.577.0	23.577.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	364.683.0	232.479.0	63.7
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	364.683.0	232.479.0	63.7
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд			
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	7.019.935.0	7.019.935.0	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	135.391.6	135.391.6	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	7.155.326.6	7.155.326.6	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	3.754.913.2	3.754.913.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	2.128.519.3	2.128.519.3	100.0
	- Соёлын байгууллага			
	- Биеийн тамир спортын байгууллага			
	- Эрүүл мэндийн байгууллага	1.115.558.2	1.115.558.2	100.0
	- Газрын кадастрын байгууллага	77.585.1	77.585.1	100.0
	- Хүүхдийн байгууллага	78.750.8	78.750.8	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан			

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2019 01- сар	2019 02- сар	<u>2019- 02</u> <u>2019-01</u> Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 200	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	7000	107.7
	Үхрийн мах /кг/	8 300	8 500	102.4
	Адууны мах /кг/	7 000	6 800	97.1
	Ямааны мах /кг/	6000	6200	103.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 800	1 500	83.3
	Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
	Тараг /задгай, л/	2 000	2 000	100.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	15 000	100.0
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0

	Өөхөн тос /кг/	2000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1000	1000	100.0
	Лууван /кг/	1200	1200	100.0
	Манжин /кг/	1200	1200	100.0
	Байцаа /кг/	1500	1500	100.0
	Сонгино /кг/	1500	1500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 645	100.0
	Бензин А - 92	1 725	1 725	95.0
	Дизелийн түлш	2 275	2 275	100.0

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Тайлант сард “Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын 2 дугаар зөвлөгөөн”-ийг Аймгийн Прокурорын газраас, “Архигүй Сэлэнгэ” сэдэвт хууль сахиулах байгууллагуудын хамтарсан уулзалт хэлэлцүүлгийг аймгийн Цагдаагийн газраас тус тус зохион байгууллаа. Хууль, хяналтын байгууллагууд хамтарсан хяналт шалгалтыг явуулж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 2 дугаар сард 146 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 9.5 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 18,7 хувьтай байна. Нийт 4530 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн нь урьд оны мөн үеэс 1180 зөрчлөөр буюу 35,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Архивын чиглэлээр

Төрийн архивын баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийх ажлын хүрээнд Зүүнхараа хотын Модны үйлдвэрийн 1965-1991 оны нийт 104 хадгаламжийн нэгжид хэсэгчилсэн тооллого, 1965-1988 оны 20 хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг тус тус хийж 6 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Түшиг, Сант сумын ЗДТГ-ын нийт 50 хадгаламжийн нэгжний 4753 хуудас баримтанд мастер хувь үүсгэсэн. Мөн хөмрөгийн 55 хадгаламжийн нэгжийн 6155 хуудас баримтын мэдээллийн агуулгыг уншиж хүний нэр-19623, байгууллагын нэр-2404, газар зүйн нэр-2429, заалт-4937 шивж эх баримттай нь холбох ажлыг хийсэн.

Албан байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу архивын магадлагаа, тодорхойлолт 30, малчин даатгуулагчид олгох архивын лавлагаа 1, иргэдэд ажилласан жилийн холбогдолтой архивын хуулбарыг цахим хувиас 116, мастер хувиас 24, цаасан суурьтай баримтаас 33 буюу нийт 173 лавлагаа гаргаж үйлчилсэн байна. Мөн Төрийн архивын тасгийн пэйж хуудсаар дамжуулан Сүхбаатар болон Налайх дүүргийн 2 иргэнд архивын лавлагааг гаргаж өгч үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

Төвийн бүсийн Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын багш нарын авьяасыг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлах, сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан туршлага солилцох зорилготой “Урлаг, спортын их наадам”-ын энэ удаагийн арга хэмжээ тус аймгийн төвд 3-р сарын 21-ний өдөр зохион

байгуулагдлаа. Арга хэмжээг Аймгийн Засаг даргын тамгын газар, Төвийн бүсийн арга зүйн төв, Сэлэнгэ аймаг дахь МСҮТ, Шаамар сум дахь МСҮТ, Зүүнхараа ПК хамтран зохион байгуулж, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн МСҮТ-ийн багш нар хамрагдлаа.

“Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд 2017 онд нийлүүлсэн STEM сургалтын хэрэглэгдэхүүнийг бага ангийн багш, сурагчид хэрхэн ашиглаж буй талаар 32 сургуулиас мэдээлэл цуглуулан нэгтгэж 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр БСШУСЯ болон төслийн албанд хүргүүлсэн. Төслийн хүрээнд сургууль бүр анги танхимын хүрэлцээ, боломжоо ашиглан STEM-ийн ширээ сандал, хэрэглэгдэхүүнийг 32 сургуулийн 75 хувь нь тусгайлсан анги танхимтай болж багш нар хичээлийн бус цагаар долоо хоногт 1 удаа 2-3 цагаар орж байна.

Бага боловсролын багш нар байгалийн ухааны туршилтат хичээлийн арга зүй, туршлагаа хуваалцаж, ажлын байрандаа хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор БМДИ-ээс зохион байгуулж байгаа “Бага боловсролын байгалийн ухааны хичээлийн үр дүнг сайжруулах нь” уралдааны эхний шатыг сургууль бүр дээр зохион байгуулж бага ангийн 362 багш оролцсон. Нэгдүгээр шатанд шалгарсан 38 багш 2 дахь шатны шалгаруулалтад оролцох эрхээ авсан.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяны хүрээнд зохион байгуулагдах “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээнд 11 сургууль, 5 цэцэрлэгийн тогооч нарийг хамруулахаар бэлтгэл хангасан.

Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын ажлыг 15 сум, 5 тосгоны Соёлын төвийн орон нутаг сурталчлах танхимд 2 дугаар сарын 26-наас 3 дугаар сарын 13-ны өдрүүдэд зохион байгуулж, бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй нийт 3172 дэсийн 4477 ширхэг үзмэрийг тоолж дуусган, тооллогын тайланг нэгтгэж байна.

Аймгийн сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд зохион байгуулагдах “Багш дуулж байна” уралдааны 1-р шатны шалгаруулалтыг бүсчлэн зохион байгуулж, нийт 107 багш оролцсоноос бүс тус бүрээс 5 багш шалгаруулж шилдэг 25 багшид 2-р шатны шалгаруулалтанд оролцох эрхийн мандатыг олгосон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Оюутны хөгжлийн асуудал эрхэлсэн орон тооны бус зөвлөлөөс зохион байгуулсан “Эерэг хандлага хөгжил” уулзалт, лекцэд Сүхбаатар сумын 11-12 дугаар ангийн 280 гаруй сурагч хамрагдсан.

БСШУС-ын сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний А/425 тоот “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын үнэлгээний төвтэй хамтран 2019 оны 3-р сарын 20, 21-ний өдрүүдэд Сүхбаатар сумын 1, 4, Мандал сумын 1 дүгээр сургуулийн 3 дугаар ангийн сурагчдаас математик, монгол хэл, хөгжим, хүн орчин, 10 дугаар ангийн сурагчдаас монгол хэл, математик, газар зүй, биологи, бүх сургуулийн 9 дүгээр ангийн 60 бүлгийн 1355 сурагчаас монгол хэл, математик, физик, англи хэлний хичээлүүдээр шалгалтыг зохион байгуулаад байна. Мөн БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газраас ирүүлсэн 2018-2019 оны хичээлийн жилд улсын төрөлжсөн хичээлийн олимпиадын 2, 3-ын давааг зохион байгуулах хуваарийн дагуу Хөтөл Ерөнхий боловсролын сургуульд биологийн олимпиадыг зохион байгуулж 9-р ангийн 33, 12-р ангийн 33 сурагч, 36 багш нийт 102 багш суралцагч хамрагдсан.

БСШУС-ын сайдын 2019 оны А/42 “Шалгалт зохион байгуулах тухай” тушаалын дагуу монгол хэл бичгийн шалгалтын босго оноог 400 байхаар тогтоосон ба 2019 оны 03 дугаар сарын 23-нд монгол хэл бичгийн шалгалтыг зохион байгуулж 18 сургуулийн 370 гаруй сурагч оролцсон.

Орон даяар сурагчдын дунд зохион байгуулж буй “Ногоон паспорт” аянд Сүхбаатар сумын 7 сургуулийн сурагчдыг хамруулан, “Ногоон паспорт” аяны цахим бүртгэлд бүртгүүлэн сургуулийн нийгмийн ажилтнуудад сурагчидтай хэрхэн яаж ажиллах тухай зөвлөн тусалж, дэмжин ажилласан.

“Нэг удаагийн нийлэг, хальсан уутнаас татгалзъя” видео уралдааныг Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвөөс 2019 оны 3-р сарын 04-нд зарласныг аймагтаа амжилттай зохион байгуулж, нийт 8 видео бичлэгийг явуулснаас Сүхбаатар сумын 3-р сургуулийн багш сурагчид амжилттай оролцож Найрамдал зусланд багш хамт

олноороо амрах эрхийн бичгээр шагнагдсан. Мөн “Байгаль хамгаалах уламжлал” гар зургийн уралдаанд нийт 34 бүтээл ирснийг тус байгууллагад хүргүүлээ.

Техник технологийн бүсийн олимпиадыг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 сургууль, Түшиг, Мандал-3, Хүдэр, Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулиуд дээр зохион байгуулж 5 бүсийн 60 багш, 70 сурагч 6 төрлөөр оролцож эхний байр эзэлсэн багш сурагчид аймгийн олимпиадад оролцох эрх авсан.

Аймгийн аварга шалгаруулах Самбо бөхийн өсвөрийн тэмцээнийг зохион байгуулж 7 сум 2 дэвжээний 9 багийн эмэгтэй 30 эрэгтэй 49 тамирчид охид 6, хөвгүүд 3 жинд өрсөлдлөө. Багийн дүнгээр:

Охид:

1-р байр О.Сарангоо дасгалжуулагчтай Шинэ бадрах дэвжээ

2-р байр н.Мөнхзаяа дасгалжуулагчтай Спортын сургууль

3-р байр Н.Баярцэцэг дасгалжуулагчтай Мандал сум

Хөвгүүд:

1-р байр Н.Ганболд дасгалжуулагчтай Сант сум

2-р байр З.Энхбаатар дасгалжуулагчтай Шинэ бадрах дэвжээ

3-р байр Сэргэлэн дасгалжуулагчтай Шаамар сумын баг тамирчид эхний байранд шалгарсан.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 02-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 753 байсан бол 211 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 74 ажлын байранд 47 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 157 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 760 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 3 сарын байдлаар 35512 иргэнд 3,810,905.0 мянган төгрөгийг олгоод байна.

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2333 иргэнд 758,664.8 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1430 иргэнд 200,645.5 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1373 иргэнд 163,998.0 мянган төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 1758 иргэнд 42,465.0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 220 иргэнд 34,142.2 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 3327 эхэд 112,989.1 мянган төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 65 иргэнд 17,269.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8606 иргэнд 1,128,900.0 мянган төгрөг
- Насны хишиг 4503 иргэнд 353,680.0 төгрөг
- Цалинтай ээж хөтөлбөр 5860 иргэнд 760,755.5 мянган төгрөг
- Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжинд 232 иргэнд 62,160.01 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 5968 иргэд 152,731.6 мянган төгрөг

Нийт 212 өрхөөс бүрэн судалгааг авч, үлдсэн 77 өрх нь хаягандаа байхгүй, ажил хийхээр Улаанбаатар хот болон бусад газар руу түр хугацаагаар явсан, алслагдсан хөдөө байгаа өрхүүд байна.

3.Эрүүл мэндийн талаар

Эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн албыг шинээр 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж албаны ажиллах чиг үүргийг тодорхойлж, эрүүл мэндийн салбарын хэмжээнд сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан гаргаж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. “Сувилагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх” сургалтыг Орхон бүсийн 7 сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 16 сувилагчийг хамрууллаа. Цаашид сургалтыг 11 ээлжээр 88 сувилагчийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

“Эрүүл хүүхэд-Сэлэнгийн ирээдүй” уриан дор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг Сүхбаатар сумын 4, 5-р сургуулиуд дээр Охид, хөвгүүд, нүд, сэтгэц, хүүхдийн эмчийн үзлэг, ахлах ангийн сурагчдын цээжний хөндийн эмгэг илрүүлэх оношлогоо, 1-5 дугаар ангийн сурагчдын цагаан хорхойн шинжилгээг хийж нийт 1100 гаруй хүүхдийг хамруулаад байна. Мөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд сургалт зохион байгуулан ажиллаж эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна.

Сүхбаатар сумын 3, 5 дугаар сургууль, Хилийн 0243 дугаар анги, Тохижилт үйлчилгээний газар, Цагдаагийн газрын албан хаагч нарт “Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зөв дадлыг хэвшүүлэх нөлөөллийн сургалт”-ыг зохион байгуулж нийт 300 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенци, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ангийн дарга нарыг чадваржуулж, тэдний манлайлыг дээшлүүлэн, хүүхэд хүмүүжүүлэх эерэг хандлагыг төлөвшүүлж, найз нөхдийн холбоог бэхжүүлэн, бие биедээ туслах, өсвөр үеийнхний аливаа үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжих, бүхий л эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “**Ангийн дарга нарын аймгийн зөвлөгөөн**”-ийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ ОНХХ-тэй хамтран зохион байгуулж 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 34 сургуулийн 5-12 дугаар ангийн 425 бүлэгт нийт 10545 сурагч, МСҮТ, политехник коллежийн 17 бүлэгт 224 суралцагчийн төлөөлөл болгон “**Ангийн дарга нарын аймгийн зөвлөгөөн**”-ийг зохион байгуулж 280 бүлгийн 335 ангийн дарга, нийгмийн ажилтан зөвлөгөөнд оролцсон.

Зөвлөгөөний үеэр анги хамт олноо манлайлан, ангийн даргаар олон жил ажиллаж урлаг, спортын авъяас чадвараа хөгжүүлэн, сурлагаараа тэргүүлэн амжилттай суралцаж байгаа 11 сурагчийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын “Эрдэм оюу”, “Тэргүүний сурагч”, “Шилдэг сурагч”, Боловсрол, соёл урлагийн газрын “Шилдэг сурагч” медалиар тус тус шагнаж урамшуулсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 8 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлж, 6 кейсыг шийдвэрлэсэн. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлөөр ангилбал бие махбодын хүчирхийлэл 2, үл хайхрах хүчирхийлэл 4, сэтгэл санааны хүчирхийлэл 2 байгаа ба 11 хүүхдэд тохиолдлын хувийн хэрэг үүсгээд байна.Бэлгийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхдийн байцаалтанд хууль ёсны төлөөлөгчөөр оролцон, сэтгэл зүйн болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, 1 хүүхдийг “Хүүхдийн эрх хамгаалал” ТББ-ын бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн нөхөн сэргээх “Үжин” төвд хүлээлгэн өглөө.

Насанд хүрээгүй 6 хүүхэд, насанд хүрэгч 7, нийт 13 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн. Алтанбулаг, Мандал сум дахь Түр хамгаалах байрны нийгмийн ажилтан, үйлчилгээний ажилтнуудад арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Мандал сум дахь Түр хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн Хөвсгөл аймгийн харъяат ээж Э нь 4 хүүхдийн хамт байрлах хугацаанд эрүүл мэндийн үзлэг хийж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газарт холбон зуучлан ажилласан.

Гэр бүлийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, нийгмийн суурь үйлчилгээнд холбон зуучлах мэдлэг чадвар олгох зорилгоор “Гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн” 270 өрхийн гэрээр айлчлагч 17 сум, 6 тосгоны 56 багийн Засаг дарга, нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ ОНХХ-тэй хамтран зохион байгуулж сургалтанд нийт 90 хүн, “Хүүхэд хамгааллын жишиг баримт бичиг”, “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагуудын хүний нөөц, бичиг хэргийн

ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт сургалт зохион байгуулж нийт 40 хүн тус тус хамрагдсан.

Каритас Олон улсын байгууллага, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран “Хүний эрхийн талаарх ойлголт”, “Хүчирхийллийн төрөл хэлбэрүүд түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Сүхбаатар сумын 8 багийн хөгжлийн бэрхшээлтэй 25 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 25 эцэг эх хамруулсан. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан Сүхбаатар, Шаамар сумын харьяат 9 хүүхдэд батлагдсан сургалтын хуваарийн дагуу хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж тус хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2018 оны 3-р сарын 28-ны байдлаар 5,4 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 3 дугаар сарын 28-ны байдлаар өссөн дүнгээр 6,1 тэр бум төгрөгийн орлого төвлөрүүлж ,111.67 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16615 тэтгэвэр авагчдад 11280.7 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 1242 хүнд 410.05 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 221 хүнд 192.8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 85 хүнд 106.1 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид олгосон.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 340 иргэн, даатгуулагчдад гарган үйлчилж, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 312 хүнээс, 21 иргэнийг цуцалж, 59 иргэнийг шинээр тогтоож, 232 иргэн актаа сунгуулсан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж буй “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье аян”-ы хүрээнд аймгийн холбогдох газрууд, аймаг дахь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй сургалт зохион байгуулж, давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, зохион байгуулахад анхаарах асуудал, сонгосон бүтээгдэхүүний давсны агууламжид хяналт шинжилгээ хийх, тэргүүн туршлагауудын талаар мэдээллийг олгосон. “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аянд оролцохоор 3 цэцэрлэг, 5 сургууль, 12 эмнэлэг, 3 хүнс үйлдвэрлэгч, 5 хоол үйлдвэрлэгч нийт 28 аж ахуйн нэгжийг бүртгэж, “Давсны зохистой хэрэглээ”-ээр гарын авлага хийж, 100 ширхэг тарааж, аян үргэлжлэн явагдаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийг тогтоох нормативын шинэчилсэн төсөл”-д аймгийн холбогдох газруудаас гаргасан 16 саналыг нэгтгэн trade@mofa.gov.mn хаягаар хүргүүлсэн.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Тайлант хугацаанд Сүхбаатар суманд газар өмчилж авсан 17, Алтанбулаг суманд газар өмчилж авсан 7 иргэнд тус тус газар өмчлөлийн захирамж, кадастрын зураг, хянан баталгааны паспортын хамт тус бүр 3 хувь үйлдэн хүлээлгэн өгч Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлж, аймгийн Засаг даргын 1 удаагийн захирамжаар 1 иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар болгов.

Аймгийн Засаг дарга болон тус газарт иргэдээс ирүүлсэн 20 өргөдлөөс 1 иргэнд албан тоотой, 3 иргэний хүсэлтийг 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал оруулахаар, 17 иргэний хүсэлтийг шийдвэрлэхээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Дархан-Уул аймагт 2-р сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан төвийн бүсийн 4 аймгийг хамруулсан “Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер

програм хангамжийн вэб хувилбар, газрын татвар, төлбөрийн систем"-ийн сургалтад 4 мэргэжилтэн, 4 сумын газрын даамлыг оролцуулсан.

Жавхлант, Баянгол сумдад зохион байгуулагдах Газар эзэмших эрхийн дуудлага худалдааны зарыг “Зууны мэдээ” сонин, газрын цахим бирж, аймгийн Засаг даргын тамгын газрын вэб сайтанд байршуулан олон нийтэд мэдээлээд байна.

Банк болон банк санхүүгийн байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалан зээл авч байгаа 162 иргэн аж аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн барьцааны бүртгэлийг газрын цахим биржид бүртгэлжүүлэн 52 иргэн аж ахуйн нэгжийн барьцааг чөлөөлж газрын мэдээлийн санд холбон ажилласан.

2019 оны 03-р сард Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 15 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сан Лэнд менежер програмд бүртгэн баталгаажуулж, Сүхбаатар сумын 26 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн үйлчилсэн.

Сүхбаатар сумын Боргүвээ 5-р багт 2 нэгж талбар, Баянхаан 4-р баг 4 нэгж талбар, Салхит 3-р багт 15 нэгж талбарыг хаягжуулалтын журмын дагуу дугаарлан, Хонгор морьт 1-р баг багт 2 нэгж талбарт нэр өгч аймгийн мэдээллийн санд бүртгэсэн. Сүхбаатар, Мандал суманд суурилуулсан байнгын ажиллагаатай станцын өндрийн алдааг шалгаж үр дүнг тухай бүр \\192.168.20.24\AimagIT\GNSS-files-д хуулах ажлыг гүйцэтгэсэн.

Мандал сумын Тэмээтийн хонхор билүүтийн голын урсацыг хуримтлуулах усан сангийн зураг төсөл, Шаамар сумын “Буман нарс ахмадын сувилал”-ийн барилга, Сүхбаатар өртөөний 180 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Сүхбаатар сумын Төмөр замын 7 дугаар багийн орон сууцны байруудын зоорийн давхрын халаалт, цэвэр, бохир усны шугамын шинэчлэлийн зураг, Сайхан сумын Соёлын ордны барилгын засварын ажил, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд явган хүний зам, дугуйн зам барих болон авто хашлага солих ажлуудын зураг төсвийг хянаж, Орхонтуул сумын Рашаант тосгонд баригдаж буй “Соёлын төв, захирагчийн алба”-ны барилга угсралтын ажилд хяналт хийж, ашиглагч байгууллага болох Орхонтуул сумын удирдлагууд, иргэдийн хурлын тэргүүлэгчтэй хуралдаж барилгын одоогийн байдал цаашид авах арга хэмжээний талаар зөвшилцөж гүйцэтгэгч “Тарнийн арцат уул” ХХК-д холбогдох үүрэг даалгаврыг өгч ажиллалаа.

Долоо.Сум орон нутгийн талаар

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд үнээ 62, эм хонь 21640, эм ямаа 9430 толгой төллөж, төл малын хорогдолгүй байна.Үхэр сүргийн үүлдэрлэг байдлын төлөв тогтоох зорилгоор “Мерси кор” ОУ-ын байгууллагаас аймгийн ХХААГазартай хамтран энэ сарын 22-өөс 24-ний өдрүүдэд тус сумын 80 өрхийн 1280 толгой үхэрт хэмжилт хийсэн.

2019 онд тариалах талбай шаардагдах үр хор, бордоо, гербицидний захиалгыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж, 2019 оны тариалалтанд нөөцөлсөн 4 аж ахуй нэгжийн үрийн дээжийг шинжилгээнд хамруулаад байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны А/60 тоот Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 2019 оны А/18 тоот Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай захирамжуудыг үндэслэн Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагуудад Ой хээрийн түймрийн сургалт зохион байгуулж, санамж бичиг гарын авлага материал тарааж ажилласан.

Цагаан-Овооны 3-р багийн ИНХурлыг 3 дугаар сарын 20-нд хийж аймаг, сумын Засаг даргаас ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар гарсан шийдвэрүүд болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар танилцуулж түймрээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо, эрх, үүргийн талаар зөвлөмж мэдээлэл өглөө.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийг 2019 оны гуравдугаар сарын 21-ний өдрийн 16 цагт зохион байгууллаа. Дадлага, сургуулилтад Засаг даргын тамгын газар, ЕБС, 25-р Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Спорт заал, Хаан банк, Төрийн банк, Петровис, зэрэг төр төсвийн байгууллагууд

оролцлоо. Дадлага сургуулийн үеэр газар хөдлөлтийн үед нүүлгэн шилжүүлэх аюулгүй цэгт цугларах дадлага хийж аймаг, сумын Засаг даргаас ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан шийдвэрүүдийг танилцуулж хаврын хуурайшилтын үе эхэлж гал түймэр гарах нөхцөл бүрдэж байгаатай холбогдуулан байгууллага, аж ахуйн нэгж бүр галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, ЕБСургуулийн хичээлийн амралт эхэлж байгаатай холбогдуулан сурагчдад гал түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулаас болгоомжил хөдөө гадаа хонь мал хариулж явах үедээ гал гаргахгүй байх талаар сануулж ажиллахыг сургуулийн захирал, багш нарт танилцууллаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс амбулаторийн үзлэг 193, урьдчилан сэргийлэх үзлэг 107, осол гэмтлийн өвчлөл 2, эмнэлэгт хэвтсэн 18 иргэн байна. Ээлжит дархлаажуулалтанд нийт 43 хүүхдийг хамрууллаа.

“Сүрьеэ өвчинтэй тэмцэх” дэлхийн өдрийг угтан 3-р сарын 18-25-ны өдрүүдэд “Цаг нь болсон” уриан дор ЕБС-ийн дотуур байрны 75 сурагчдад “Сүрьеэ өвчний тухай” мэдээлэл сургалт явуулж, 75 сурталчилгааны материал тарааж, сурагчдын дунд асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулж урамшууллаа.

Сумын 20-45 насны иргэдэд компьютерийн анхан болон ахисан шатны 7 хоногийн сургалтыг явуулж, сумын хэмжээнд “Сайн үйлсийн аян”-ыг үргэлжлүүлэн зохион байгуулж, Соёлын төв, Спорт цогцолбор, Орхон бүсийн сум дундын Ойн ангийн хамт олон Ивэнгийн 1-р багийн малчин Ж. Очирсүрэнгийн хүүхдийн хувцас болон сарын хэрэгцээт хүнсээр тусалж, дараагийн аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн, иргэдийг нэгдэхийг уриаллаа.

Хүүхэд хэрэглэгч үндэсний өдрийн хүрээнд сарын аяныг зохион байгуулж, Сайхан сумын цагдаагийн хэлтсээс 6-12 дугаар ангийн сурагчдад хүүхдийн эрх үүрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг явуулж, зөвлөмж зөвлөгөө өглөө. Аянд оролцогч хүүхэд багачуудынхаа оролцоог дэмжих, хүүхдийг хүүхдээр нь дамжуулан зөв хэрэглээнд сургах, нийгэмд тулгамдаж буй эрүүл ахуй, аюулгүй шаардлагыг хангасан баталгаат хоол хүнсний талаарх хүүхдийн дуу хоолойг сонсох, тэдний санал санаачлагыг холбогдох байгууллагуудад уламжлах зорилгоор “ХҮҮХЭД ХЭРЭГЛЭГЧ” сэдвийн хүрээнд 3 агуулгаас сонгож эсээ бичих уралдааныг зарлалаа.

Мөн Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн баяр, “Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сурагчдын дунд АХА, чанга шивнээ, Дэвжээ, ээждээ захидал бичээрэй сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, цэвэр ус болон усан хангамж, усны нөөцийн тогтвортой менежментийн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, сурталчлан таниулах ач холбогдолтой юм. 6-12-р ангиудын дунд сурталчилгааны ханын сонингийн үзэсгэлэн гаргалаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, туслах багш нарыг чадавхижуулах зорилгоор “Тоглонгоо хөгжье” сэдэвтнээлттэй хөгжүүлэх үйл ажиллагааг явуулж, туршлага солилцох арга хэмжээг зохион байгууллаа.

Сайхан сум дахь Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч, сургуулийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран ЕБС-ийн 7-12 дугаар ангийн 107 хүүхдэд цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тус сургалтыг зохион байгууллаа.

Мандал сум:

Улс орон даяар зохион байгуулагдсан Газар хөдлөлтийн үед ажиллах дадлага сургуулийг сумын хэмжээнд зохион байгуулж, сумын гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, 26 аж ахуй нэгж байгууллагын 4075 ажилтан, иргэд хамрагдлаа

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойг суманд үйл ажиллагаа явуулж буй тусгайлсан чиг үүрэг бүхий цэрэгжүүлсэн байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулж, марш тактик, тусгай бэлтгэл 2019 оны аварга тасаг шалгаруулах тэмцээн ийг сумын Засаг даргын дэмжлэгтэйгээр зохион байгуул, тэргүүн байрыг ШШГЕГ харьяа 433-р анги, дэд байрыг ШШГЕГ харьяа 413-р ангийн багууд эзэллээ. Цэрэгжүүлсэн байгууллагуудын үйл

ажиллагааг сурталчлах, тэдний ёс зүйн хандлага, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Эерэг хандлагыг өөрчилье” сэдэвт арга хэмжээг мөн зохион байгуулж, 500 гаруй албан хаагчид, сургуулийн ахлах ангийн эрэгтэй сурагчдыг хамрууллаа.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас “Хариуцлагатай хэрэглээ-Хэрэглэгчийн эрхийн жил”, аймгийн Засаг даргын 2019 оны А/75 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэгчийн эрхийг хамгаалах хөтөлбөр, хууль тогтоомжийг сурталчилах сургалтыг 623 албан хаагч, иргэдэд хийсэн. “Аюулгүй ухаалаг бараа бүтээгдэхүүн өдөрлөг”-ийг суманд үйл ажиллагаа явуулдаг Тэнгэр, Томун, Вест, Өсөх, Буд, Тод зэрэг томоохон 13 худалдааны төвүүдэд зохион байгуулж, аюулгүй ухаалаг бараа бүтээгдэхүүн, газны зохистой хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүнийг улсын кодоор таних, бараа бүтээгдэхүүний хадгалах хугацааг хянах, насанд хүрээгүй хүүхдэд худалдан борлуулж болохгүй бараа бүтээгдэхүүн зэрэг сэдвүүдээр иргэдэд гарын авлага материал тарааж, мэдээлэл хийлээ.

Олон Улсын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өдөр буюуж 3-р сарын 15-ны өдрийг “Хүүхэд-хэрэглэгч” Үндэсний өдөр болгон тэмдэглэж, Ерөнхий боловсролын 2658 сурагчдад сургалт зохион байгууллаа.

Мандал сумын аварга” шалгаруулах шатрын тэмцээнийг 6 насны ангилалаар зохион байгуулж, 4 шатрын клубын 92 шатарчид оролцлоо.

“Хүүхдийн эсрэг хүчирхийллийг тэг болгоё” аяны хүрээнд “Flash mob” challenge хөдөлгөөнд хүүхдийн хүчирхийллийн эсрэг үзэл бодлоо бүжгийн хөдөлгөөнөөр илэрхийлэн бусдад үлгэр дуурайлал үзүүлэн, манлайлж 2-р сургуулийн 200 сурагч, 25 багш, 3-р сургуулийн 400 сурагч, 4-р сургуулийн 120 сурагч, Төрийн банкны 21 ажилтан, Хас банкны 12 ажилтан, Зүүнхараа ачааны вагон засварын депогийн 326 ажилтан, “Спирт бал бурам” ХХК-ий 52 ажилтан нийт 7 байгууллагын 720 сурагчид, 436 ажилтан албан хаагчид нэгдэж өөрсдийн олон нийтийн цахим хуудсанд өөрсдийн бичлэгээ байршуулан идэвх зүтгэлтэй амжилттай оролцлоо. “Хүслийн хөтөч” хүүхэд хамгаалал оролцооны клубын хүүхдүүдээ чадваржуулах зорилгоор Дэлхийн зөн Зүүнхараа ОНХ- тэй хамтран “Хүүхдийн оролцоогоор дамжуулан үнэлгээ дүгнэлт хийх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдлэг мэдээллийг өгсөн.

Монголын эмэгтэйчүүдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хөөрхөн зүрх” ТББ, хүний эрхийн иргэний нийгмийн байгууллагууд нэгдэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө олон улсын арга хэмжээг урлагаар дамжуулан илэрхийлдэг бөгөөд энэ онд 3 дугаар сарын 7, 8-ны өдөр 7 дахь жилдээ жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч буюу даван туулагчдын дуу хоолойг олон нийтэд түгээн, таслан зогсоохыг уриалж 100 гаруй эмэгтэйчүүдийг хамруулан “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭВ НЭГДЛИЙН ХАНА” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Мөн Дотуур байрны хүүхдийн эрх хамгаалалд хувь нэмэр оруулах зорилгоор 1,4, хэрх сургуулийн нийт 159 хүүхдэд “Харилцаа ба хандлага” сэдэвт сургалтыг “Дэлхийн зөн” ЗХОНХ-тэй хамтран амжилттай зохион байгууллаа.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж бүтэн өнчин хүүхдийг асран хамгаалж байгаа иргэнд олгох тэтгэмж болон тэжээгчийн тэтгэвэр-1, байнгын асаргаа шаардлагатай ахмад шинээр-1, сунгалт-6, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд шинээр-1, сунгалт-2, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр-2, сунгалт-6, 0-18 насны 3 хүүхэдтэй өрх толгойлсон эхэд тэтгэмж-31 /шинээр-4, сунгалт-27/ иргэнд олгохоор нийт 50 иргэний өргөдлийг шийдвэрлэлээ. Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний мэргэжилтнүүдтэй хамтран өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаж 12-р сард оноо нь бодогдсон 40 өрхөд дахин хяналт хийв.

Сумын малчдын сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж, 9 багийн 250 гаруй малчид оролцож, шинээр батлагдсан хууль тогтоомж, мал аж ахуйн салбарт баримталж буй бодлого чиглэл, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, зохиомол хээлтүүлэг хийх шинжлэх ухааны онол, туршлагын талаар иргэдэд сургалт мэдээлэл бэлтгэн хүргэлээ. Мөн “Ногоочдын сургалт, зөвлөгөөн 2019” арга хэмжээ амжилттай зохион байгуулж, Монгол улсад Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойг тохиолдуулан

төмсний хүнсний ногооны салбараас төрөн гарсан Улсын аварга ногоочид, төмсний салааны ахлагч, тракторч, тоо бүртгэгч, агротехникчид, аймгийн аварга ногоочиддоо хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа. Далд хөрсний улсын хошой аварга бригадын дарга Н.Янжмаа, Улсын аварга тариаланч Н.Бадралхүү нар залуу хойч хандаж мэдээлэл өглөө. “Монгол ногоо” төсөл, МХЕГ-тай хамтран ХАА-н зохимстой дадал, хууль эрхзүйн орчин, Ургамал хамгаалал хорио цээрийн арга, гарал үүслийн гэрчилгээ сэдвээр сургалт зохион байгуулж, 183 ногоочныг хамрууллаа.

2019 онд талбай тусгаарлалт хийлгэх 14 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу 12 аж ахуйн нэгж байгууллагад 202 га-д талбай тусгаарлалт хийж талбай тусгаарлалтын материалыг боловсруулан ажиллаа. ХанХэнтий улсын тусгай хамгаалалттай газарт 2 ойн мэргэжлийн байгууллагад 32 га талбайд тусгаарлалтын ажил хийсэн. Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичигийг 15 ААНБ-д 2358 м³ хэрэглээ, 643 м³ түлээ, 2 нөхөрлөл 7 иргэнд 31 м³ түлээний эрхийн бичиг олгож, 165 ширхэг гарал үүслийн гэрчилгээнд хэрэглээ 2225,7 м³, түлээ 481 м³ нийт 2706,7 м³-ийг бичиж олгосон.

Олон нийтийн цахим хаягаар “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ойн сан бүхий газарт тээврийн хэрэгсэлээр зорчихдоо оч баригч хийх зэрэг 22 удаагийн ухуулга сурталчилгааг ард иргэдэд хүргэж, шторк, мэдээлүүдийг 7 хоногт 2-3 удаа явуулж байна.

Сумын нутаг дэвсгэрийн ойн сан бүхий газар нутгийн 7 чиглэлийн гол зам дагуу болон бусад салаа замуудад ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын нийт 7 байнгын ажиллагаатай хяналтын цэг, 52 ширхэг сургалт сурталчилгааны самбарыг байрлуулж, мод бэлтгэл, аялал зугаалга, ашигт малтмал олборлох чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ихээр зорчдог Ялбаг, Цагаан тохой, Бугант, чиглэлийн, Хатангийн даваа Ерөөгийн халуун рашаан, ХХУТХГазар нутаг чиглэлийн төв замын уулзварт Бар чулууны хяналтын цэгийг байршуулан ажиллаж, бичил уул уурхай эрхлэгчдийн дээвэр холбоо, онцгой байдлын газар, бороо гоулд ХХК, хувиараа алт олборлогч, БОХТ-тай хамтран бичил уул уурхай эрхчлэгчдийн сургалт Түнхэл тосгон зохион байгуулагдан нийт 100 бичил уул уурхай эрхлэгч хамрагдсан. Мөн сумын мод бэлтгэлийн ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлийн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Төрийн байгууллагаас 17 албан хаагч, 30 Ойн мэргэжлийн байгууллагын 199 ажилчид, 21 ойн нөхөрлөлийн 41 ахлагч, гишүүн нийт 258 хүн хамрагдлаа. Зөвлөгөөнөөр аймгийн БОАЖГазраас 2019 онд баримталж буй бодлого чиглэл, үйл ажиллагаа, Өмнөх онуудад үйлдэгдсэн байгаль орчны эсрэг гэмт хэрэг, түүний шийдвэрлэлт, 2017 оны 7-р сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн “Эрүүгийн хуулийн зохицуулалт”, Нийгмийн даатгалын тухай хууль түүний ач холбогдол ба зөрчил, НӨАТ-ын урамшуулалын системийн талаар, Байгаль Орчны тухай хууль, Ойн тухай хууль, 2018 оны гэрээний дүгнэлт, 2019 оны мод бэлтгэх гэрээ, Ойг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдал, 2019 оны Мод бэлтгэлийн Гэрээ” зэрэг сэдвээр мэдээлэл хийлээ.

Орхон сум

Орхон сумын Эмэгтэйчүүдийн баярыг 2019 оны 03 сарын 07-ны өдөр сумын ИТХ, ЗДТГ, Эмэгтэйчүүдийн холбоо хамтран зохион байгуулж, зарим эмэгтэйчүүдийг шагнаж урамшууллаа. Сумын Монголын Эмэгтэйчүүдийн холбооны салбар зөвлөлөөс жил бүр шалгаруулдаг тэргүүний шилдэг эмэгтэйчүүдээ тодруулж Шилдэг төрийн албан хаагч эмэгтэйгээр ЕБС-ийн захирал Б.Соёлмаа, Шилдэг малчин эмэгтэйгээр Б.Эрдэнэчимэг, Шилдэг тариаланч эмэгтэйгээр Б.Эрдэнэцэцэг, Шилдэг хөдөлмөрч эмэгтэйгээр Н.Бямбасүрэн нарыг тодорсон байна.

“Малчид, тариаланчдын хамтарсан зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, Сэлэнгэ аймагт газар тариалан мал ахуйн чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийн талаарх мэдээлэл, тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохиролыг тооцох аргачлалын талаарх танилцуулга,

сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний товч танилцуулга, гэрээ байгуулах тухай зэрэг асуудлаар хэлэлцсэн.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2019 оны 03 сарын 13-ны өдөр Орхон суманд ажиллаж аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, төр төсвийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж Орхон сум жишиг болохуйц олон шинэлэг арга хэмжээг зохион байгуулсан сайн дүнтэй үнэлэгдлээ.

Аймгийн Засаг даргын “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” 2019 оны А/76 дугаар захирамжийн хүрээнд Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгууллаа. Тус аврах ажиллагаагаар Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийг аюулгүй цэгт нүүлгэн шилжүүлэх, иргэдийг объектоос гаргах, гамшигт өртсөн хүүхдүүдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зэрэг ажиллагаануудыг ЭМТ, мэргэжлийн ангийн аврагчид гүйцэтгэж нийт 142 иргэнийг хамруулан “Аюулгүйн цэгт шилжин байрших”, “Нүүлгэн шилжүүлэх” тактикийн дадлага сургуулийн үйл ажиллагаа хийгдлээ.

2019 оны 03-р сарын 15-ны өдөр “Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “АЮУЛГҮЙ, УХААЛАГ БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН” өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулж сумын Засаг даргын орлогчоор ахлуулсанажлын хэсэг төлөвлөгөө боловсруулан сумын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хадгалалт хамгаалалт, бүтээгдэхүүний хугацаа, сав баглаа боодол, шинжилгээний бичиг, худалдагчийн эрүүл мэндийн дэвтэр, үзлэг шинжилгээнд хамрагдсан байдал, тусгай зөвшөөрөл зэргийг шалгалаа.

Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах чиглэлээр харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан бичиж хэвших ажлыг зохион байгуулах талаар төр төсвийн байгууллага, худалдаа үйлчилгээний газруудад албан тоот хүргүүллээ.

Хамтарсан баг:

Орхон сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 2019 оны 29 дүгээртогтоол гаргуулан 5 зорилт 46 заалтын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар батлууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2014-2018 онуудад төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн судалгаа, 2019 онд хэрэгжих төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй өрхийн саналыг тус тус авч нэгтгэн аймгийн ХХҮГ-т хүргүүллээ.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд нийт 552 иргэнд 59274820 төгрөгийг олгож ажилласан.

Нийгмийн даатгалын алба нь 03-р сард дараахи ажлыг хийж ирлээ. Төсөв аж ахуй нэгж байгууллагаас шимтгэлийн орлого 18070.4 мянган төгрөг, сайн дурын даатгалд 45 даатгуулагчийн 2075.6 мянган төгрөг, ЭМД-д 15 даатгуулагчийн 784.4 мянган төгрөгийг санд оруулж ирлээ. Нийгмийн даатгалын сангуудын хуваарилалтыг хийсэн. Үүнд: Тэтгэвэрийн санд 13437.4 мянган төгрөг, Тэтгэмжийн санд 1514,9 мянган төгрөг, ҮОМШӨ-ний санд 1369,9 мянган төгрөг, ЭМД-ын санд 3501,3 мянган төгрөг, ажилгүйдэлийн санд 322,3 мянган төгрөгийн хуваарилалтыг хийлээ.

ДЗОУБ, тус сургуулийн БАХҮАБ хамтран I-VI ангийн сурагчдын дунд “Ухаант хүү” даамны тэмцээнийг I-III, IV-VI анги, эрэгтэй эмэтэй төрлөөр зохион байгуулахад нийт 80 хүүхэд хамрагдаж манлайлсан 16 сурагчийг тоглолтын стандарт шатраар шагнаж урамшуулсан.

“Хүүхэд хэрэглэгч” өдрийг тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд 2019 оны 03 дугаа сарын 15-ны өдөр “Хүүхэд хэрэглэгч-Хэрэглээний боловсрол” сургалтыг бага

ангийн сурагчдад “Хүсний бүтээгдэхүүнийг сонгон авах хадгалах”, дунд ангийн сурагчдад “Ундны усны хэрэглээ, усны савыг сонгож хэрэглэх”, ахлах ангийн сурагчдад “Хувцсаа өөртөө тааруулах сонгох, худалдан авах” сэвдээр АУБ нар сургалтыг зохион байгуулан яриа таниулга хийж, ярилцлага, хэлэлцүүлгийн аргаар зохион байгуулсан.

Хамран сургалтыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд гэр бүлд түшиглэсэн сургалтанд хамрагдаж буй 2-р багийн малчин Ц.Бат-Өлзийгийн 4 настай Түвшинбаяр, 5 настай Төрболд нар даалгавраа шалгуулан тэдэнд нэмэлт даалгавар болон гарын авлага, бичих, зурах дадлагын ном хүлээлгэн өгсөн.

Орхон 12-р цэцэрлэгээс хүүхдүүдийн авъяас чадварыг нэмэгдүүлэн хөгжүүлэх, тэднийг аймаг, улсын чанартай уралдаан тэмцээнд бэлтгэн оруулахад бэлдэх зорилгоор “Хүүхдүүдтэйгээ хамтдаа ” уриан дор жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Уран жиргээ-2019 ” уран уншлагын тэмцээнийг 2019 оны 03-р сарын 12-ны өдөр зохион явууллаа. “Уран жиргээ” уран уншлагын тэмцээнийг Сэлэнгэ аймгийн “Дэлхийн зөн” ОУБ, 12-р цэцэрлэгтэй хамтран зохион явуулж тэмцээнд оролцсон нийт хүүхдүүдийг гарын бэлгээр шагнаж урамшуулсан.

ЕБС, цэцэрлэг, дотуур байрны 157 хүүхдийг амны амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хамруулж, шүдний өвчлөл, хоолой залгиурын өөрчлөлттэй 110 хүүхдийн багш, эцэг эх, асран халамжлагч нарт эмчилж эрүүлжүүлэх зөвлөгөө өглөө.

Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Хэрвээ бид бүсгүйчүүд байсан бол” тэмцээнийг 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, тэмцээнд 4 баг авъяас билиг, ур чадвараа сорин өрсөлдөж, “Ээ дээ энэ хүүхнүүд үү” баг тэргүүн байр, удаах байрыг ЕБС-ийн “Эрдмийн элч”, ЭМТ-ийн “Энэрэл”, 12-р цэцэрлэгийн “Цоморлиг” багууд тус тус эзэллээ. Музейн үзмэрийн улсын тооллогод Орон нутгийг судлах танхимын 92 ширхэг үзмэрийг хамрууллаа.

Хаврын тариалалтын ажил эхлэхтэй холбогдуулан Хаан банкттай хамтран тариаланчид ногоочидтой зээл олголтын талаар бизнес уулзалт зохион байгуулсан.

Тариалангийн талбайн оготно устгалын ажлыг 03 дугаар сарын 20-ноос 31-ний хооронд сумын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар хийх болсон тул газар эзэмшиж байгаа ААН, иргэдэд албан мэдэгдлийг утсаар болон албан мэдэгдэл өглөө.

Сумын Засаг даргын “Ой хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх тухай” 2019 оны А/28 дугаар захирамжийн хүрээнд сургалт сурталчилгаа зохион байгуулах, ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, хариуцлагатай жижүүрийн хуваарь, “Ой, хээрийн түймрийн үед ажиллах аврах бүлгийг томилох тухай” 2019 оны А/27 дугаар захирамжийг батлуулан ажиллаж байна.

2019 онд ойгоос мод бэлтгэх хуваарийн дагуу Баруунбүрэн сумаас бэлтгэх модны гэрээг хоёр сумын Засаг дарга нарын хооронд байгуулан, гэрээнд заасны дагуу мод бэлтгэл, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан бөгөөд 60 метр куб гишүү, 64 метр куб мод бэлтгээд байна.

Сумын хэмжээнд 03 дугаар сарын 01-ны өдрийг “Бүх нийтийн их цэвэрлэгээний өдөр” болгон зарлаж, айл өрх, аж ахуй нэгж байгууллагууд ойр орчмынхоо 50-100м газрын хог хаягдал, нийтийн эзэмшлийн 50 га газрын ил задгай гялгар уут, хуванцар сав, ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажил хийгдсэн.

Сант сүм:

Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариалангийн бие даасан салбар болон хөгжсөний түүхт 60 жилийн ойг суманд тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/19 тоот захирамжаар байгуулан ойн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сумын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдлагууд, эрдэмтэн багш нартай уулзалт ярилцлага зохион байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар харилцан санал солилцож хамтран ажиллах санамж бичгийг байгууллаа.

Ивэн 1-р багийн иргэдийн Нийтийн Хурал 3-р сарын 22-нд хуралдаж, 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг багийн иргэдэд тавьж 125 иргэн хамрагдлаа. Энэ

үеэр Бэлчээр ашиглалтын журам, Орон нутгийн хөгжлийн сангийн тухай, “Цэвэр ус-тэгш хэрэглээ”, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн талаарх мэдээллийг сумын Засаг даргын Тамгын газраас хийж, хэрэглэгчийн эрхийн тухай ойлголт, аюулгүй бараа бүтээгдэхүүний тэмдэг тэмдэглэгээ сэдэвт гарын авлага зөвлөмжийг тараалаа.

Сумын хэмжээнд 3-р сарын 6-аас 10-ны өдрүүдэд бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, 8 аж ахуйн нэгж байгууллага, 187 иргэн оролцож, 61 га талбайн 45 м.куб хогийг хогийн цэгт тээвэрлэн хаясан байна.

Сумын хэмжээнд 3-р сарын 22-ны байдлаар адуу 13, үхэр 58, хонь 1380, ямаа 1070, бүгд 2521 эх мал төллөж, төлийн хорогдолгүй бойжиж байна. Том малын зүй бус хорогдол адуу 12, үхэр 19, хонь 50, ямаа 7, бүгд 88 байна. Үүнээс хээлтэгч мал 25 хорогдсон дүнтэй байна. 2019 онд бүртгэлжүүлэлтэд хамрагдах хээлтүүлэгчийн судалгааг гаргаж, сумын хэмжээнд 96 бух, 206 хуц, 154 ухна байгаагаас бух 72, хуц 160, ухна 105-ыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн санд оруулахаар захиалгыг өгөөд байна.

“Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 онд “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-гаас олгож байгаа жимс жимсгэний суулгацын хүүгүй зээлд 4 иргэний хүсэлтээр чавганы суулгац 47 ширхэг, бэсрэг алимны суулгац 224 ширхэг, чацарганы суулгац 21 ширхэг нийт 292 ширхэг суулгац захиалж, хаврын тариалалтын ажил эхлэж арилжааны банкууд тариалалтын зээл олгож байгаатай холбогдуулан төмс, хүнсний ногоо тариалах 31 иргэнд тариалалтын тодорхойлолт олгон талбайн түүх хөтлөх талаар мэлээлэл өгсөн. Аймгийн төв Сүхбаатар суманд 3-р сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан “Мал эмнэлгийн салбарын үйл ажиллагаа, стандарт, чиг үүрэг, гарал үүсэл баталгаажуулалт, цахим бүртгэл, мөрдөн, мөшгөх тогтолцоо” сэдэвт сургалтанд “Бошгын булаг” МЭҮН-ийн малын эмч, “Сант баян хархан” МЭҮН-ийн малын эмч нарыг хамруулсан.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 3-р сарын 7-ны өдөр “Төлчин эмэгтэйчүүдийн уулзалт өдөрлөг”-ийг зохион байгуулж, 86 малчин эмэгтэйчүүд оролцлоо. Арга хэмжээний үеэр мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээлэл, “Хүнээс малд халдварладаг зарим өвчнүүд, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сургалт, “Дундын хадгаламжийн бүлэг байгуулах, түүний ач холбогдол” сэдвээр тус тус мэдээлэл өгч, сумын Залуучуудын холбооноос витаминжуулах ажлыг зохион байгуулж, төлчин эмэгтэйчүүдийн санаачлагаар “Сайн үйлсийн аян”-ыг өрнүүлж, Хушаат багийн иргэн Б.Уранчимэг, өндөр настан Х.Мужин нарт хүндэтгэл үзүүлж, хичээлийн хэрэглэл, мөнгөн дэмжлэг үзүүлсэн.

Мөн Олон Улсын ойн өдөр, Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “Ойн тухай хуулийн хэрэгжилт ба иргэдийн оролцоо” сэдэвт сургалт, “Цэвэр ус-тэгш хэрэглээ” сэдвээр мэдээлэл хүргэж 132 иргэнийг хамрууллаа. “Малын эрүүл мэндийн тухай” хууль, төр засгаас баримталж байгаа бодлого шийдвэрийн талаар мэдээлэл сургалтыг зохион байгуулж 50 гаруй малчин иргэдийг, 2-р багийн Усан сээр, Дулаан, Үзүүр цохионы 3 хэсэг малчдын бүлгийн 44 малчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, амьтны тухай, ойн ашиглалтын талаар мэдээлэл зөвлөмж хүргэж Олон Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн” өдөрлөгийг зохион байгуулж, сумын хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл, салбар зөвлөлөөс хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг сурталчилах арга хэмжээг зохион байгуулж 50 гаруй төрийн албан хаагч, 120 сурагч, 135 иргэн хамрагдсан.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулагдах тухай аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд сумын хэмжээнд дадлага сургуулийн ажил явагдаж 9 аж ахуйн нэгж, байгууллагын 214 иргэн хамрагдлаа. Сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А\24 тоот захирамжийн дагуу ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх жижүүрийн хуваарь гарган ажиллаж аймгийн БОАЖГ, ОБГ болон Сайхан сумын Гал унтраах, аврах 61-р ангид өдөр тутамд шуурхай мэдээллийг өгч ажилласан. Аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах үзлэг шалгалтыг тус суманд зохион

байгуулж, сумын дүнгээр 74 хувьтай үнэлэгдсэн байна. Сумын Онцгой комисс болон гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнд “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх тухай” сургалт мэдээлэл өглөө.

Тайлант сард бусад аймаг сумаас шилжин 10, баг хоорондын хөдөлгөөн 5, эцэг эхээ дагаж шилжин ирсэн хүүхэд 11 бүртгэгдсэн байна. Иргэний шинэчилсэн бүртгэл болон иргэний үнэмлэх олголтын ажлын хүрээнд 12 иргэний үнэмлэхийг олгож ажиллалаа.

Сумын ЭМТ-өөс “Охидын эрхийг хамгаалах өдөр” аяныг зохион байгуулж, 6-12 дугаар ангийн 53 охидод эрүүл мэндийн үзлэг хийж, охидын эрүүл мэндийн талаар зөвлөгөө өгч, 1-5 дугаар ангийн охидод “Амны хөндийн эрүүл мэнд”, “Гарын ариун цэвэр” сэдвээр дунд, ахлах ангийн охидуудад “Шилжилтийн нас ба охидын эрүүл мэнд” сэдэвт сургалт хийж, гарын авлага тараасан. Мөн 6-11 дүгээр ангийн 70 охидод “Охидын оролцоо” сэдвийн дор шилжилтийн насны охидод тулгамдаж буй асуудлуудаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр охидыг 3 баг болгон хувааж “Охидын хамгаалал”, “Охидын оролцоо”, “Охидын эрүүл мэнд” сэдвүүдээр асуудлуудыг хөндөж шийдвэрлэх арга замын талаар хэлэлцлээ.

Сайхан сум:

Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 98 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан сумын эрчүүддээ хүндэтгэл үзүүлэх үүднээс “МОНГОЛ ЦЭРЭГ-98” арга хэмжээг амжилттай зохион байгуулж, 2019 онд 18 нас хүрч буй залуусд цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулан, суманд амьдарч буй цэрэг, хүчний байгууллагад ажиллаж байгаад ахмад настаны тэтгэвэртээ гарсан ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн, монгол цэргийн залгамж халааг сурталчлан таниулах арга хэмжээ боллоо.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчдын дунд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтач, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх, хууль, эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Архигүй, Авлигагүй, Тамхигүй” спортын арга хэмжээг сумын хэмжээнд 9 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд нийт 12 багийн 180 ажилтан, албан хаагч хамрагдан оролцлоо. Тус тэмцээн Сагсан бөмбөг, Волейбол, дартс, теннис гэсэн төрлөөр явагдсан бөгөөд тэмцээний үеэр Архи, Авлига, Тамхины талаар ААНБайгууллагууд сургалт сурталчилгаа гарын авлага, тараах материалыг иргэд албан хаагч нарт хүргэсэн байна.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх” дадлага сургуулилт, бэлэн байдлын талаар Сайхан сумын хэмжээнд 2018 оны 03 сарын 20-ний өдөр таниулах сургалт өдөрлөг зохион байгуулж мэргэжлийн ангиудын байдлыг шалгав Мөн Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор 24-р цэцэрлэг дээр зохион байгуулсан дадлага сургуулилтанд мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн тусламж үзүүлэн, дадлага сургуулилтанд амжилттай оролцов.

Тус суманд аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчид ажиллаж, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 аж аухуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийж хор гербицид, бордооний нийллэг хуванцар сав боодлыг шатааж устгахгүй байх талаар зөвлөмжийг өгсөн.

Атрын 60 жилийн ойг угтан сумын үе үеийн атарчдын судалгаа болон усалгаатай талбай, техник хэрэгслийн судалгаа, тэжээл үйлдвэрлэгчдийн судалгаа, малчны үнэмлэхтэй иргэдийн судалгаа, гадаадаас мал амьтан үржүүлгийн бүтээгдэхүүн авах, гадаадад мал амьтан гаргах болон авах талаарх судалгаа, үржилд ашиглаж буй бух, хуц, ухна, цөм сүргийн малыг ялган тэмдэгжүүлэх талаар нийт 4 төрлийн судалгааг гаргаж аймгийн ХХААГазарт хүргүүлэв.

3-р сарын 25-ны байдлаар сумын нийт төллөлт 4079 буюу 4,3 хувь байна.

“Хөх сэрхийн өвөр” ББН, “Цөм сүрэг” МЭҮН-ийн 1-р улирлын тайлан мэдээ болон 2020 онд халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал, шаардагдах

эм бэлдмэлийн захиалгыг гаргаж аймгийн Мал эмнэлгийн газарт файлаар болон бичгээр хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолын дагуу 2019 оны Баруунбүрэн сумтай иргэдийн түлээний мод бэлтгэл гэрээ байгуулж Сайхан сумын харъяат 23 иргэн, Орхон сумын харъяат 15 иргэнд нийт 65 м3 мод модон материалд тээвэрлэлтэд гарал үүслийн гэрчилгээний бичилт бичиж, Баруунбүрэн сумын ойн нөөц ашигласны төлбөр дансанд 97 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагын 2019 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталсан бөгөөд сумын хэмжээнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх захирамжийн төсөл болон хавар намрын хуурайшилтийн үед хяналт тавин ажиллах хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулах төслийн тус тус давхар боловсруулан ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” 189 дүгээр тогтоолын хэрэгжүүлэн ажиллах хүрээнд сумын Худалдаа үйлчилгээ эрхлэгч болон баялаг бүтээгчидтэй хамран хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгээр Баялаг бүтээгчдийн холбооноос өөрсдийн хийсэн даавуун уутыг танилцуулан 1 дэлгүүрт 10 даавуун уут байрлуулахаар болсон. Мөн сумын лого болон баялаг бүтээгчдийн холбооны логог тус тус даавуун уутанд байрлуулахаар болсон байна.

2019 онд Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх нийтийн орон сууцны барилгын дээвэр, фасадын ажлын талаар дахин хэлэлцэж, эцэслэн шийдвэрлэлээ. Номгон Эрүүл мэндийн төвийн шугам хагарч барилгын суурь усаар дүүрснээр тус барилгын хийцэд нөлөөлөн суулт өгч хана, тааз хагарсан асуудлыг газар дээр нь очиж шалгалаа. Барилгад учирсан нөхцөл байдалд мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гаргуулах, Онцгой байдлын албаны дүгнэлтийг мөн хавсарган холбогдох байгууллагад уламжлах шийдвэрийг гаргалаа.

Сүхбаатар сум

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам”-ын дагуу жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх пүрэв гарагийн 16:00 цагт Гамшгийн аюул тулгарсан үед аж ахуйн нэгж байгууллагын бэлэн байдлыг хангуулах, иргэдийг гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллуулах дадлага суургуулилтад тус сумын Засаг даргын Тамгын газар нь урьдчилан бэлтгэлийг хангаж цугларах цэг тэмдгийг бэлтгэн, гамшгийн үед хэрэглэх хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйлсийн жагсаалтыг бэлтгэн 23 албан хаагч оролцсон. Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг иргэд олон нийтэд таниулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, сургалт, дадлагын талаар өөрийн цахим хаягаар Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, Багийн иргэдэд мэдээллийг хүргэн ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд тус сумын Засаг даргын Тамгын газрын нийт 43 албан хаагчдын хувийн мэдээлэл болон үндсэн цалин хөлс болон сар бүр тогтмол авдаг нэмэгдлүүдийг үрэн тусган оруулж, албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулж, харилцан туршлага солилцох, мэдээ мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Мэдээллийн цаг” арга хэмжээг долоо хоног бүрийн Даваа гариг бүрийн 17.00 цагт ажил төрлийн ярианы үед зохион байгуулан ажиллаж байна.

Сургууль цэцэрлэгүүдийн бүтэц орон тоо ажиллах хүчний нөөц сурах бичгийн хангалт мэргэжлийн багшийн хангалт зэрэгт хяналт тавин аймгийн статистик мэдээнд оруулах судалгааг гарган хүргүүлж, 1-р цэцэрлэг, 7-р цэцэрлэгт дулааны хангамж түлшний нөөцийн хангалтыг хянан байгаль хамгаалагчтай хамтран түлш олгох ажлыг зохион байгуулсан.

ЭЭШ-д 800 оноо авсан 2-р сургуулийн багш Чимгээ, сурагч Хатан-эрдэнэ нарыг Засаг даргын шагналд тодорхойлон багшийг 500,0 сурагчийг 300,0 төгрөгөөр тус тус шагнаж журмын дагуу тус тус шагнаж урамшууллаа.

Сүхбаатар сумын аварга шалгаруулах Шагайн харвааны тэмцээнийг сумын Шагайн харвааны холбоотой хамтран 2019 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Спорт сургууль дээр зохион байгууллаа. Тэмцээн багийн харваа, цуваа харваа төрлөөр явагдаж, 8 багийн 32 тамирчин өрсөлдөж, шилдгүүдээ тодрууллаа.

Сурагчдын бие бялдрын хөгжлийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх, тус спортоор дамжуулан тэсвэр хатуужил, багаар ажиллах чадварт сургах, бага наснаас зөв системтэйгээр өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх, сурагчдын ур чадварыг сайжруулах, шинэ залуу баг тамирчин бэлтгэх зорилгоор Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд “Сурагчдын лиг-2019” сагсан бөмбөгийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнийг Ерөнхий боловсролын Спортын сургуультай хамтран 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс зохион байгуулж эхлээд байна.

Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэгээс зохион байгуулсан “Саруул ухаанд-Эрүүл бие” сэдэвт элэг, улаан хоолой болон ходоодны хавдраас урьдчилан сэргийлэх сургалтанд байгууллагын нийт албан хаагчдыг хамрууллаа.

Аймгийн ИТХ-аар батлагдсан “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах аймгийн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, ард иргэдийн эрүүл амьдралын хэв маягийг өөрчлөх, мэдлэг олгох зорилгын хүрээнд Сүхбаатар сумын Тохижилт үйлчилгээний газрын нийт 35 ажилтанд “Халдварт бус өвчин, түүний эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэлт”, “Эрүүл зөв хооллолт”, “Элэгний вирусын оношлогоо, эмчилгээ” сэдвээр Эрүүл мэндийн газрын эмч, мэргэжилтнүүд сургалт зохион байгууллаа.

2020 онд Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 68195 толгой мал амьтанд шаардагдах 11 төрлийн эм био бэлдмэл, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 64000 толгой малд шаардагдах эм бэлдмэл, 1319 толгой малд Лабораторийн шинжилгээнд шаардагдах оношлох био бэлдмэл, Ариутгал халдваргүйтгэлийг 43,2 м2 талбайд хийх захиалгийг төлөвлөж Засаг даргаар баталгаажуулан аймгийн мал эмнэлгийн газарт албан тоотоор хүргүүлэн ажиллалаа.

Гахайн мялзан өвчний голомтын бүсэд байгаа зориудаар гахайгаа устгуулсан 21 өрхийн 8180 м3 тайлбайд эцсийн халдваргүйжүүлэлтийг бүрэн хийж Хорио цээр, Хязгаарлалтын дэглэмийг татан буулгах Засаг даргын захирамж гарган ажиллалаа.

Цаг агаар огцом дулаарлаас үүдэн нимгэн цасан бүрхүүл хурдан хайлж, гол зарим газраараа харзлан урсах, мөсний зузаан нимгэрэн цөмрөх аюултай болж байгаатай холбогдуулан мөсөн замаар тээвэр хийхийг хориглосон сэрэмжлүүлэгийг 8 баг болон Сэлэнгэ Сүхбаатар сум Сэлэнгэ аймаг пейж хуудсанд мэдээлэлж иргэдэд хүргэн ажилласан.

МУ-н Шадар сайд, БОАЖ-н сайдын хамтарсан тушаал, Сэлэнгэ аймгийн Засаг даргын захирамж, Онцгой байдлын газрын үүргийн дагуу Ой хээр, Орон байрны түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах түүнтэй тэмцэх арга хэмжээг, орон нутагт зохион байгуулах 2019 оны ажлын төлөвлөгөө батлуулан мөрдөж ажиллаж байна.

Мөн Сүхбаатар сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2018 судалгаа, сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль бус олборлолтын хэрэг, зөрчилтэй 7-н иргэний талаарх судалгааг гаргаж хүргүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 189 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд худалдаа, үйлчилгээ эрхлэгч 30 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд нэг удаагийн нийлэг хальсан уут хориглосон тухай тогтоолыг хүргүүлж, Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны улсын байцаагч нар хамтран СТИЛЬ, Сэлэнгэ талст, Бялхам цайны газар, Янгир цайны газар зэрэг газруудад хог хаягдлаа цэвэрлэх, ойр орчмын газраа камержуулах албан шаардлага өгч, Гурван мэргэд захын орчим худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдээр ойр орчмын хогийг цэвэрлүүлэн ажиллалаа.

Хүдэр сум:

Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариалангийн бие даасан салбар болон хөгжсөний түүхт 60 жилийн ойн арга хэмжээг энэ онд зохион байгуулахаар төлөвлөөд байна. Уг арга хэмжээний хүрээнд газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, Атрын 1,2,3-р аянд оролцож байсан илгээлтээр ирсэн үе үеийн удирдлагууд, ахмадууд, одоо ажиллаж байгаа хүмүүсийг “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, “Засгийн газрын шагнал олгох журам”-ын дагуу 142 хүнийг материалыг бүрдүүлээд Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар оруулан хэлэлцүүлж тогтоол шийдвэр гаргуулан Сэлэнгэ аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. ХХААГ-т нэрсийн жагсаалтыг mail хаягаар явуулав.

Сумын хэмжээний хээлтүүлэгч 73 толгой мал цуглуулан суурилан маллаж байгаа малчинтай уулзан хээлтүүлэгч малыг хаврын амьд жин тогтоох, ээмэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 10 гаруй малчин өрхөөр орж төл бойжилтын мэдээ, мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, малын генетикийн хууль талаарх мэдээ мэдээлэл хийж, хаврын хуурайшилтын талаар ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага тарааж сурталчилж ажилласан.

Аймгийн ХХААГ-т долоо хоногийн 2 дахь өдөр мал төллөлтийн мэдээг тогтмол өгч байна. Сумын хэмжээнд нийт малын 10% төллөж эхлээд байна. Малчид болон мал бүхий иргэдийн төл мал хүлээн авах бэлтгэл ажил мал төллөлтийн байдал урьд жилүүдээс хэвийн сайн эхлэж байна.

Аймгийн ХХААГ-т суманд газар тариалангийн үйл ажиллагаа явуулдаг ААНэгжийн техникийн судалгаа явуулсан.

Сумын ойн сангийн нийт талбай 205.561 га буюу 72.4-г эзэлж байна. Үүнээс ойн талбай 203513 га, үүнээс ойжиж байгаа талбай 1445 га, ойжуулсан талбай 630 га, шатсан талбай, 22423 га, Нийт ойн сангийн талбайг 221 хэсэглэлд хуваан 18 нөхөрлөл, ойн мэрэгжлийн байгууллага 35 үүнээс ойн мэрэгжлийн байгууллага 19, үйлдвэрлэлийн огтлолтын эрхтэй 11, байгууллага нийтдээ 290,017 га талбайг эзэмшиж байна. Ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар нөхөрлөл, ААНэгжүүдэд гэрээгээр эзэмшин ашиглаж, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн БОАЖГазраас ойн албаны дарга Г.Цэнгэлзаяа даргатай ажлын хэсэг ирж Сумын ИТХурлын Төлөөлөгч болон ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгжүүдэд ойн тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Дээрх сургалтанд 11 ойн мэргэжлийн байгууллага, 8 нөхөрлөл, ИТХурлын төлөөлөгчид оролцсон болно.

Сумын иргэдэд хаврын хуурайшилт эхэлсэнтэй холбогдуулан сумын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран Ойн тухай хууль, Ой хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулж, гарын авлага тараах материал өгсөн. Ойгоос бэлтгэх модны хуваарь батлагдсантай холбогдуулан ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдэд зөвлөмж хүргүүлэн, дээд байгууллагас ирсэн албан бичиг тоотыг цаг тухайд нь танилцуулан мэргэжил аргагүйгээр ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар 11 аж ахуй нэгж 1 нөхөрлөл Зэрлэг, Янгаахай, Шоргоолж, Зээгийн нуруу, Оорцог, Халтын нуруу, Харанхуй ам, Чулуут гол, Бэлт уул, Зэлт гол, Бүдүүн зэрэг газруудад нийт 245 га талбайд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтыг хийлгэж Хэрэглээний 2690 м3 мод Түлээний мод 1097 м3 нийт 3787 м3 мод бэлтгэгдэж мод бэлтгэлийн гүйцэтгэл 16.7 хувьтай байна.

Эрх зүйн сургалт сурталчилгааны нээлтийг хийж Ойн анги, Хөдөлмөр эрхлэлт нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, Төрийн захиргаа, хууль эрх зүйн нар иргэдэд хууль эрх зүйн сургалт сурталчилгааг хүргэлээ. Сургалтанд 26 иргэн хамрагдсан. Үүнд: 1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, 3. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар тус тус сургалтийг зохион байгууллаа.

Олон Улсын эмэгтэйчүүдийн баярыг Угтан жил бүр уламжлал болгон явагддаг сумын шилдэг 9 эмэгтэйг тодруулан Ачлалт ээж, Уран бэр, дархан бэрийг алдаршуулах арга хэмжээг сумын Эмэгтэйчүүлийн холбоотой хамтран зохион

байгуулан ажиллаа. Мөн Цэргийн баярыг тохиолдуулан Хилийн 0236-р салбар ангитай хамтран иргэдийн дунд марш тактикийн тэмцээнийг зохион байгууллаа.

Хушаат сум:

Энэ сард байгаль орчны чиглэлээр ойн нөөцийн төлбөр өссөн дүнгээр 466900 төгрөг, хог хаягдал үүсгэсний хураамж 925500 төгрөгийг төсөвт орууллаа. Мөн 38 ш эрхийн бичиг, 6 ш арал үүслийн гэрчилгээг бичиж тайланд тусган Баруунбүрэн дэх Ойн ангид хүргүүллээ. Сумын Засаг даргын захирамжаар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, морьт эргүүлийн хуваарийг батлууллаа. 1 малчны өвөлжөө шатан 25 хүн, 6 автомашин, ажиллан унтрааж 3 өдөр манаж Гацуурт ХХК-ийн ковшоор түрж овоолон бүрэн унтраалаа. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгааг 136 өрхөд хийн 5ш үлээгч, 50ш цохиур троссон шүүрийг бэлтгэлээ.

Гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг 16 цагт дуугарган дуут дохиогоор нийт 102 иргэн цугларлаа.

Мөнхтолгой 2-р багийн нутагт байрлах өвөлжөөнүүдэд 'Colden Map' ХХК-тай хамтран кадастрын зураг хийж, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийсэн. Сумын хэмжээнд төмс хүнсний ногооны үйлдвэрлэл явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагын газрын хэмжээг баталгаажуулах, газрыг дур мэдэн зөвшөөрөлгүй хагалж, тэлсэн эсэхийг тогтоох зорилгоор тооллого хяналт шалгалтын ажлын хэсэг Сумын Засаг даргын захирамжаар байгууллаа Даагат багийн 65 малчин өрхийн 195 хүнд "Малын генетик нөөцийн" тухай хууль, Малын чанар сайжруулахад Зохиомол хээлтүүлгийн ач холбогдол, шинээр батлагдсан "Стратеги төлөвлөгөө", "Бэлчээрийн журам", "эрчимжсэн МАА" хөтөлбөр сэдвүүдээр сургалт мэдээлэл өгч гарын авлагаар хангалаа.

Сумын хэмжээнд 3-р сарын байдлаар 10695 эх мал төллөж 10695 төл гарснаас 11 төлийн хорогдол гарч 10684 төл мэнд бойжиж, төл бойжилт 99,9 хувьтай, мал төллөлт 27 хувьтай байна.Том малын хорогдол нийт 35 , үүнээс 9 хээлтэгч хорогдсон мэдээтэй байна. Аймгийн ЖДҮС-ын мэргэжилтэнтэй хамтран зээлийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, зээлтэй 27 иргэнээс нэг иргэн төлөлт хийж бүгд 3 иргэн бүрэн төлөлт хийж 24 иргэн 71,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

"Төрийн албан хаагчдын 4-р зөвлөгөөн"-ийг "Яргуй" цэцэрлэгийн хамт олноос зохион байгууллаа. Зөвлөгөөний үеэр Төрийн албан хаагчдын андгай өргөх ёслолын арга хэмжээ болж "Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга", "Нийгмийн даатгалын тухай хуулийн өөрчлөлт", "Хувь хүний орлогын албан татварын тухай" сургалт мэдээллийг хийлээ. Зөвлөгөөний нэрэмжит гар бөмбөг, шатрын тэмцээнийг явуулсан бөгөөд гар бөмбөгийн тэмцээнд ЕБС-ийн баг 1-р байр, Соёлын төвийн баг 2-р байр, Цэцэрлэгийн баг 3-р байр эзэлжээ. Шатрын тэмцээнд эрэгтэй ЭМТ-ийн жолооч Т.Гэрэлтуяа тэргүүлж Соёлын төвийн эрхлэгч Б.Хүсэлт 2-р байр, ЗДТГ-ын Санхүү албаны дарга О.Цогбаяр 3-р байр , эмэгтэй шатрын 1-р байр ЕБС-ийн хими биологийн багш С.Хишигмаа, 2-р байрыг ЭМТ-ийн эмийн санч М.Отгон, 3-р байрыг Цэцэрлэгийн туслах багш Д.Цэцэгсүрэн нар эзэлжээ.

Сумын ГХУСАЗЗөвлөл, сумын ЗДТГ, "Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг"-тэй байгуулсан хамтранажиллах гэрээний дагуу лектор Ж.Цогтсугар, тус нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн Улсын начин, лектор Нямхүү нар хүрэлцэн ирж "Оюун тархины нууц" буюу "Сэтгэлгээний шинэчлэл ба Тархины гайхамшиг" лекц, шийдвэр гаргагч нар, төр төсвийн байгууллагын ажилтнуудад зориулан "Оюун тархины нууц" "Шийдвэр гаргагчдын хандлагын өөрчлөлт, сахилга хариуцлага" лекцүүдээ хүргэн ярилцлага зохион байгууллаа. Лекцэнд 150 гаруй иргэн хамрагдлаа.

Олон Улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан сумын Эмэгтэйчүүдийн холбооны урилгаар лектор багш Ц.Амартүвшин, М.Нарантуяа / дуучин Нара/ нар ирж "Эмэгтэйчүүдийн манлайлал" сэдэвт уулзалт сургалтыг зохион байгуулж эмэгтэйчүүдтэй санал бодлоо солилцлоо. Энэхүү арга хэмжээнд оролцсон 150 эмэгтэйд "Ази фарм" ХХК-ийн оруулж ирсэн витаминь комплекс, хүүхдийн витаминьг бэлэглэлээ.Мөн сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл, аймгийн "Миний Монгол" ТВ-тэй хамтран зохион байгуулсан "Хушаат нутгийн бахархалт ээжүүд" цэнгүүн нэвтрүүлэгт

олон хүүхэд төрүүлж өсгөн үр хүүхдээ сайн боловсролтой, сайхан сэтгэлтэй иргэн болгохын төлөө сэтгэл зүрхээ зориулж яваа одонт ээжүүд, Хушаат нутгийнхаа хөгжил цэцэглэлтийн төлөө хүчин зүтгэж амжилт гаргаж яваа 40 гаруй ээжүүд оролцон хууч яриа өрнүүлж өөрсдийн чин сэтгэлийн үгээр мэндчилгээ дэвшүүллээ.

Төр нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн Наваандоржийн Жадамба агсны мэндэлсний 120 жилийн ойг уугуул нутагт нь тэмдэглэлээ. БХИС-ийн багш, доктор С.Нарангэрэл Н.Жадамба агсаныг 10 жил судлан ажилласан ба арга хэмжээний үеэр түүний намтар, Монголын төр нийгэмд байгуулсан гавьяа зүтгэл, хэлмэгдлийн талаар ард иргэдэд танилцууллаа. Н.Жадамба агсны ач зээ нараас сумын Орон нутаг судлах танхимд дурсгал үлдээж сумын Засаг даргын захирамжаар түүнийг сумын "Хүндэт дэвтэр"-т бичин мөнхжүүлж ирээдүй хойч үедээ үлдээсэнээ илтгэн "Батламж" гардууллаа.

Хушаат сум 2014 оноос эхлэн "Архигүй сум" аян, хөдөлгөөнийг өрнүүлж багагүй амжилтанд хүрээд байгаа. Энэ ажлыг эрчимжүүлэн аймгийн "Архидалттай тэмцэх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргаас санаачилж төр, төсвийн байгууллагадаа энэ ажилдаа улам их амжилт гаргахыг уриалж "Архидалт, авилгаас ангид байгууллага, хамт олон" уриалгыг гарган сурталчиллаа.

Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Хушаат сумын уугуул Н.Жадамба агсны мэндэлсний 120 насны ойн нэрэмжит Үндэсний бөхийн барилдаанд хүчит 32 бөх барилдаж аймгийн начин Х.Чинбат түрүүлэн аймгийн харцага Ж.Бадрал үзүүрлэж сумын заан Х.Отгон-өлзий, сумын начин Х.Дарханбаатар нар шөвгөрлөө. Мөн уламжлал болгон явуулдаг "Би эр хүн" тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 9-н тамирчид оролцож авхаалж самбаа хүч тамираа сорин уралдаж :1-р байр Х.Отгон-Өлзий , 2-р байр Х.Дарханбаатар , 3-р байр Х.Өлзийбат , Тусгай байранд:М.Хурцаа, Х.Өлзий-Орших нар тэргүүллээ.1-р байрын шагналыг Н.Энхбаяр агсны хүү Н.Наранбаярын гэр бүл жил бүр уламжлал болгон ивээн тэтгэж байхаар албан ёсоор зарлаж энэ удаагийн шагнал болох Цом, Өргөмжлөл ,мөнгөн шагналд 150,000 төгрөг , 2-р байрын шагналд, Өргөмжлөл 120,000 төгрөг , 3-р Өргөмжлөл 80,000 төгрөг , тусгай байр тус бүр 50,000 төгрөг,Өргөмжлөл шагналыг гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ.Тусгай байрын шагналыг Ахмад дайчин Ч.Арвагын хүү А.Нармандахын гэр бүлээс 50,000 төгрөг, Өргөмжлөлийн хамт гардуулан өглөө

Улсын бүртгэлийн тухай, Иргэний бүртгэлийн тухай хууль бусад холбогдох хууль журмын хүрээнд нотлох баримтуудыг үндэслэн дараахь бүртгэлүүдийг хийлээ. Төрөлт 4, эцэг тогтоолт 3, гэрлэлт цуцлуулсны 2, шилжин ирсний 9, өөр аймаг хотоос 2, насанд хүрэгч 7, 0-16 насны 4 хүүхдийн хамт , баг хооронд , насанд хүрэгч 2, 0-16 насны 3 хүүхдийн хамт, нас барсны 1, биеийн давхцахгүй өгөгдлийн 5, үл хөдлөх хөрөнгийн эрхийн 2, газар өмчлөх эрхийн 6, иргэний үнэмлэх олголтын 19, нийт 51 бүртгэл хийж 5 гэрчилгээ бичиж олгов. Төрийн сан банкны орон нутгийн дансанд 25500, УБХ-ийн дансанд 93000 төгрөгийн орлого оруулсан байна.

Тайлант сард Татварын орлогын төлөвлөгөө 18332,0 сая төгрөг төлөвлөгдснөөс гүйцэтгэл нь 15342,8 буюу 83,7 хувийн биелэлттэй ажиллалаа.

Номыг бүтээлчээр унших соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 12 бүлэг ангидаа номын сантай болж, фондын үйл ажиллагааг тогтмолжуулж, ангийн онцлог, сургуулийн үйл ажиллагаанд уялдуулж ангидаа ном унших цаг гаргаж, номын тэмдэглэл хөтлөх, ойлгож ухаарснаа бусдадаа ярих, зурах, зохион найруулж бичих зэрэг чадвараа хөгжүүлж байна."Багш хөгжлийн төв"-ийг сургуулийн ашиглагдахгүй буланг ашиглан шинээр бий болгов. Эцэг эхийн спортын өдөрлөг зохион байгуулж, бооцоотой гар бөмбөгийн тэмцээн явуулж, цугларсан мөнгөний тал хувь /350.000/ төгрөгийг сургуулийн авто зогсоолыг шинэчлэн засварлахад зориулахаар шийдвэрлэн, эцэг эхчүүд идэвхтэй оролцохоо мэдэгдэв. Багш ажиллагсдын ирцийн бүртгэлд хяналт тавих үүднээс хурууны хээ дарагч бүртгэлийн стандартын төхөөрөмж байршууллаа.

Зам тээврийн аюулгүй байдал осол гэмтлээс сэргийлэх ажлыг 10 нас хүртэлх хүүхдийн эцэг эхтэй гэрээ байгуулан сургуулиас тарах, ирэхэд тосон авах, сургуулийн ойр орчимд эргүүлд гарах ажлыг бүлгийн багш нар хийж байна. "School police" замын эргүүлийг 1 анги 7 хоногийн турш хийж хэвшсэн. Зам тээврийн ослоос урьдчилан

сэргийлэх, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох урьдчилан сэргийлэх талаар 254 сурагчдад яриа таниулга хийсэн.Сургуулийн орчинд гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 6-9 ангийн 20 сурагчийн бүрэлдэхүүнтэй “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийг тогтмол ажиллуулсан.

“Өсвөр нас ба шилжилтийн насны охидын эрүүл мэнд” сургалтыг дотуур байрны багш Б.Наранцэцэгтэй хамтран дотуур байрны охидод зориулж зохион байгууллаа. “Хүүхэд хэрэглэгч” аяны хүрээнд ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд “Зөв дадал-Эрүүл хэрэглээ” сэдэвт зөвлөгөө, ярилцлагыг зохион байгууллаа.

Цэцэрлэгийн Хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт:03 сарын 01нээс 03 сарын 29-ний байдлаар хамран сургалт нийт 2000 хүүхэд хүлээн авахаас 1691 хүүхэд авч ирц 84.5 %-тай байна. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх “Цөм” хөтөлбөрийн дагуу Бага, Дунд, Ахлах, Бэлтгэл бүлгийн хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж үйл ажиллагааг зохион байгуулж байна. Бэлтгэл бүлэг “Монгол орны байгаль” , Ахлах бүлэг “Таван хошуу мал”,Дунд бүлэг “Амьтан”, Бага бүлэг “Ус” сэдвээр хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан бага насны хүүхдийн онцлог, хөгжлийг дэмжих 7 чиглэлээр сургалтыг зохион байгуулж байна. Цэцэрлэгийн нийт бүлгүүдийн дунд “Миний ээж хөөрхөн” бүтээлийг шалгаруулав. Мөн уламжлал болгон “Тэр бөх хэний бөх вэ?” тэмцээнийг ЗАН-ээс зохион байгууллаа. Үүнд: Ахлах, Бэлтгэл бүлгийн хөвгүүд хамрагдаж 1-р байр Энхзориг, 2-р байр Бүрэнбаяр, 3-р байр Бавуу нар орсон.

Түшиг сум:

Байгаль орчин аялал жуулчлалын дэд сайд Ц.Батбаяр ажлын хэсгийн бүрэлдэхүүнТүшиг суманд ажиллаж ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдалтай танилцлаа. Мөн аймгийн Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн дарга дэд хурандаа Д.Ганхүүгээр ахлуулан ажлын хэсэг 03 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Түшиг суманд ажиллаж, Улсын онцгой комиссын 01 албан даалгаврын хэрэгжилт, ой хээрийн түймрийн үед эхний ээлжинд гарч ажиллах бүлэг, сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнд сургалт зохион байгууллаа.

2019 оны 3-р сарын 22-нд сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг иргэдэд танилцуулж, нийт 65 иргэн оролцлоо.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Малчдын зөвлөгөөн”-ийг 2019 оны 03-р сарын 20-нд сумын соёлын төвд зохион байгуулж, ЗДТГ-ын албан хаагчид малчдад тулгамдаж буй цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, малчин болон мал бүхий 32 иргэн оролцож, Мал амьтаны эрүүл мэндийн тухай хууль болоод Улс, аймгийн аварга малчин шалгаруулахжурмын талаар гарын авлага тараалаа.

Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Монгол цэргийн өдөрт зориулсан баярын арга хэмжээнд “Түшиг харгуй” ХХК тай хамтран уран жолоодлогын тэмцээнийг явуулж 20 жолооч тэмцээнд оролцлоо. Мөн “Цэрэгжүүлсэн буухиа” тэмцээнийг зохион байгуулж 6 баг оролцсоноос 1-р байр ЗДТГ-ын “Соёмбо баг”, 2-р байр Ар-нуга 2-р багийн “Сүлд” баг, 3-р байрыг ЕБС-ийн “Хилчид” баг тус тус эзэлсэн байна.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээжүүдээ алдаршуулья” хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж 8 ээжийг алдаршуулж тэдэнд зориулж хүүхэд багачуудын бэлдсэн урлагийн тоглолтоор үйлчилж 150 иргэд үзэж сонирхлоо. “Таван оч” ХХК-тай хамтран “99 сарнай коктейл цэнгүүн”-ийг зохион байгуулж, 65 эмэгтэйчүүд оролцууллаа. Арга хэмжээний хүрээнд азын сугалаа сугалуулж, оролцсон эмэгтэйчүүдээс 8 азтанг шалгарууллаа.

Сар бүр зохион байгуулж буй “Ахмад настнаа хүндэтгэе” арга хэмжээг ЭМТ-ийн хамт зохион байгуулж, нийт 15 нэр төрлийн эмчилгээний хоол, ногооны зууш, салатаар үйлчилж, урьдчилан сэргийлэх үйлчилгээ 65, витаминжуулалт 76, толгойн бариа 20, бумба 18, хөнгөлттэй эмээр 32 хүнд үйлчиллээ.

Энэ сард эмнэлэгт 23 хүнийг хэвтэн эмчилж, 5эх төрсөнөөс сумандаа 2, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 3 эхийг төрүүлсэн. Одоогийн байдлаар жирэмсний хяналтанд 3 эхийг шинээр авч, эхний 3 сартай хяналт 2, нийт 12 эх хяналтанд байна.

Осол гэмтлийн өвчлөл 5 тохиолдол бүртгэгдсэнээс, гадна артерийн гипертензи буюу чихрийн шижний хэв шинж 2, элэгнийхортхавдрынэртилрүүлэхүзлэгт 94 иргэнийг хамруулаад байна.Товлолт дархлаажуулалтанд 29 хүүхэд хамрагдаж дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гарсангүй.

2019 оны 03 дугаар сард шинээр төрсөн 5, эцэг тогтоолт 1, иргэний үнэмлэх олголт 1, иргэний үнэмлэх захиалсан 3, иргэний үнэмлэхний сунгалт 3, шилжин ирсэн 7 иргэн байна.

Сэлэнгэ бүсийн техник,технологын багш, сурагчдын олимпиадыг 03 дугаар сарын 09 нд зохион байгуулж нийт 24 багш сурагчид оролцлоо. “Сэтгэх чадвар-XVII” олимпиадын 1-ийн давааг 1-12 –р ангийн дунд зохион байгуулж 86 сурагч амжилттай оролцлоо.

Боловсролын үнэлгээний төвөөс жил бүр зохион байгуулдаг чанарын үнэлгээний судалгааны шалгалтыг БСУГ-ын даргын тушаалаар томилогдон ирсэн Алтанбулаг сумын ЕБС-ийн захирал Эрдэнэ-очир, С.Нэргүй багштай 9-р ангийн сурагчдаас чанарын үнэлгээний шалгалт, мэдээлэл технологийн багш нараас асуулга авч 2 өдөр ажиллаа.1-5 ангийн 7 багш болон дотуур байрны багш, нярав, тогооч, сургуулийн эмч нарыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан.

“Иргэнээ дэмжье- Хүрч үйлчилье” сэдэвт ажлын хүрээнд Ар-Нуга 2-р багийн өндөр настан С.Сувдаагийнд очиж явуулын урлаг соёлын болон нүүдлийн номын үйлчигээг хүргэх ажлыг зохион байгууллаа.МУСТА уртын дуучин С.Дуламаагийн “Ижи хайр” тоглолт ирж 120 үзэгч үзэж сонирхлоо. Эх орончдын баярын өдөрт зориулан МУСТА Н.Нарангэрэл, Лхамгарьд нар чөлөөт уран бүтээлчдийн хамт хүрэлцэн ирж урлагын тоглолт хийлээ.

“Түшиг брэнд” бүтээлч эмэгтэйчүүдийн үзэсгэлэнд 9 эмэгтэй оролцож, даршилсан ногоо,нэхмэл хатгамал даавуун торны оёдол, эко зөгийн бал, цаасан болон шүрэн гэсэн 8 төрлийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж 32 иргэн үзэж сонирхлоо.

Цагааннуур сум:

Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийнхэн тус суманд ажиллаж, сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдал, ой хээрийн түймрийн багаж хэрэгслийн нөөцийг шалгаж, түймэр унтраах үлээгч, ус ширшигч ирмак гардуулж өглөө.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас тус суманд төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулж, хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөмж өглөө.

Аймгийн Шүүхийн Тамгын газраас ирэгд, төрийн албан хаагчид болон шинээр сонгогдсон сумын ИТХ-ын төлөөлөгчдөд Иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний болон захиргааны хэргийн шүүхэд мэдүүлэх эрх, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

“Мерси кор” ОЖ-ын байгууллагаас онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандартын сургалтыг зохион байгуулж, 27 иргэн хамрагдсан.

Мөн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, “Хэрэглээ ба хандлага”, “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох нь сэдвээр сумын иргэдэд сургалт явуулж, 22 иргэн хамрагдлаа.

“Дэвс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяныг хэрэгжүүлж, худалдаа үйлчилгээ эрхлэгч 4 аж ахуйн нэгж, 5 цайны газарт мэдээ мэдээлэл хүргэж, ЕБС, эмнэлэг, цэцэрлэгт хэрхэн хэрэгжүүлэх талаар чиглэл өглөө.

Малын гоц халдварт гахайн африкийн мялзан өвчний хязгаарлалтын дэглэмийг 3-р сарын 12-нд цуцалсан.

Шаамар сум:

Сумын Засаг даргын 2019 оны А/08, А/09, А/10 тоот захирамжийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, үдийн цай хөтөлбөр, 18 дугаар цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, тендерийн баримт бичгийн бүрдлийн шаардлагыг хангасан бичиг баримтыг бүрдүүлэн олон нийтэд мэдээлэх ажлыг хуулийн хугацаанд www.tender.gov.mn цахим хуудаст тендерийн урилгыг байршуулан ажилласан. ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчээр “Сэлэнгэ Буман Буудай” ХХК, “Монтир транс” ХХК, “Өсөх Эрдэнэт Сүрэг” ББН, “АМСӨҮР” ХХК, “Дархан хүнс” ХХК зэрэг аж ахуй нэгж байгууллагууд шалгарч хуулийн хугацаанд ажил гүйцэтгэх гэрээг байгуулахаар захиалагчид хүсэлтээ хүргүүлээ. Мөн Шаамар сумын ИТХ-ийн 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 67 дугаар тогтоолоор батлагдсан хог түрж, ачдаг тракторийг худалдан авах тендерийг зохион байгуулахаар ажлын хэсэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 03 сарын 15-ны өдрийн А/76 тоот захирамжийн дагуу “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах” тухай, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу иргэд, байгууллага, аж ахуй нэгжүүдэд “Газар хөдлөлт”-ийн талаарх сургалт сурталчилгааг таниулах ажлыг 2019 оны 03 дугаар сарын 20 ний өдөр зохион байгуулж, сургалтыг ЗДТГ-ын БОХ-ын Улсын байцаагч Б.Онон, Байгаль хамгаалагч Ж.Алтангэрэл нар явууллаа. Үүнд: 7 байгууллагын 87 албан хаагчийг хамруулж газар хөдлөлтийн гамшгийн мэдээлэл олголоо.

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2019 оны 03 дугаар сарын 20 ны өдөр “Сирень дохио-SDM-550” дуут дохиололын удирдлагын фульт, холболтын кабелийн бэлэн байдлыг шалгаж журмын дагуу 1-2 удаагийн давтамжтайгаар /1 удаа 20 секунд байхаар/ ажиллуулж дуут дохионы тархалтыг хэмжиж үзэхэд Дэлгэрхааны 1 дүгээр багийн 5-н толгойн захын хэсэг, 43-р точик болон Охиндий 2-дугаар багийн бүүргийн 1, 2-р хэсгийн цаад захын орчмын айл өрхүүдэд дохио маш сул дуулдсан тул тухай хэсгийн идэвхитэн иргэдийг дуут дохиолол дамжуулах сайн дурын гишүүнээр үүрэгжүүлж арга зүйн зааварчилгаагаар хангалаа. Шаамар сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнд багтдаг байгууллагын удирдлагуудын 70 гаруй хувь нь дээд байгууллагын шийдвэрээр томилолтоор ажиллаж байсан тул сумын Гамшгаас хамгаалах штабын бүрэлдэхүүнийг цуглуулж сумын Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн томилгоот албан хаагчдын тодотголыг хийж судалгааг шинэчиллээ.

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчний байгууллага үүсэн байгуулагдсаны 98 жилийн ой, “МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ийг тохиолдуулан сумын цэргийн насны болон бэлтгэл зэрэгтэн залуучууд, эрчүүдийн бие бялдарыг чийрэгжүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “ЭРЧҮҮДЭЭ УРАГШАА” спортын олон төрлийн арга хэмжээг явуулж, сумын залуучуудын идэвхи санаачлагыг өрнүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, батлан хамгаалах бодлого шийдвэрийг сум орон нутагт сурталчлах арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Үүнд: Цэрэг спортын “Он жавууд” буухиа тэмцээн, гар бөмбөгийн тэмцээн, үндэсний бөхийн залуучуудын цол олгох барилдаан, гар барилдаан, үндэсний сурын бооцоот харвааны тэмцээн болон “Цэргийн тухай дууг хэн сайн дуулах бэ” дууны тэмцээнүүдийг сумын төр, төсвийн байгууллага, спортын холбоодтой хамтран зохион байгууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарийн ивээл дор “Бяцхан мисс-2019” уралдаант тэмцээн 2019.03.06-ны өдөр Соёлын төвийн урлагийн их танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Уралдаанд авъяаслаг бяцхан 13 мисс оролцсоноос 1 дүгээр цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн суралцагч О.Маргад тэргүүн мисс, 2 дугаар цэцэрлэгийн суралцагч М.Энэрэл загварлаг мисс, М.Хүслэн авъяаслаг мисс, Дулаанхаан тосгоны 11 дүгээр цэцэрлэгийн суралцагч Э.Учрал дуучин мисс, н.Цэцэрлэг бүжигчин миссээр тус тус шалгарч өргөмжлөл, тууз, мөнгөн шагналыг гардуулан өглөө.

ХАА-н тасгийн мал зүйч, 1, 2 дугаар багийн Засаг дарга нар хамтран орон нутгийн малчин иргэдийн төл хүлээн авах бэлтгэл ажилтай танилцсан. 2019 оны 03 сарын 24-ны байдлаар Дэлгэрхаан 1 дүгээр багт тугал 69, хурга 85, ишиг 100, Охиндий 2 дугаар багт тугал 62, хурга 104, ишиг 92, Дулаанхаан 3 дугаар багт тугал 30, хурга 43, ишиг 50 нийт 635 төл бойжиж байна.

Орон нутгийн төсөвт байгууллагууд болох Ерөнхий боловсролын сургууль, 1 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, МСҮТ-ийн өдрийн хоолонд хоёр 2 удаа хяналт тавьж ажиллахад гарсан зөрчил байхгүй болно. Сумын малын нэгдсэн тоог МЭҮН тус бүрээр боловсруулан батлуулж халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах малд шаардагдах эм био бэлдмэлийн захиалгыг 56 дугаар маягтаар, празиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал шаардагдах эм био бэлдмэлийн захиалгыг 57, 58 дугаар маягтаар гарган холбогдох байгууллагад хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн “Давс багатай бүтээгдэхүүн үйлвэрлэлийг дэмжье” аян зохион байгуулах тухай А/25 тоот захирамжийг 1 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, ЕБС, Эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгч мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан. Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээг зөгийн аж ахуй эрхэлдэг 3 аж ахуй нэгж, 8 иргэний зөгийн аж ахуйн байр болон бал савлалтын стандарт гормын талаар хяналт тавьж хамтран ажилласан.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” 01 тоот албан даалгаврын хүрээнд гахайн аж ахуй эрхлэгч иргэдэд гахайн өвчний талаар сэрэмжлүүлэг мэдээллийг өгч, урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөн ажилласан. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 06 сарын 20-ны өдрийн “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” тогтоолын дагуу 2019 оны 03 сарын 01-ны өдрөөс эхлэн нийлэг уутыг хэрэглэхгүй байх талаар мэдээллийг иргэд, төр төсвийн байгууллага, аж ахуй нэгжүүдэд танилцуулан, сумын цахим хуудсаар мэдээлж ажилласан.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах 34 өргөдөл хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шаардлагатай материалуудыг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж дээд шатны байгууллагад уламжлан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид хамрууллаа. “Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ”-ний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 12 өрхийн 86 гишүүнд 2019 оны 3 дугаар сарын талон болох 124 ширхэг үнэт цаас бүхий 992.0 мянган төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох “Бүтээл сан” ХХК-ийн “Шонхлой” хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

Тайлант сард шинээр төрсөн эрэгтэй 3 нийт 3 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгож, шилжин ирсэн 6 иргэнийг нотлох баримтын дагуу хаяг дээр нь бүртгэж, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд анх удаа шинээр 6, 25, 45 насны солиулах 4, нийт 10 иргэнийг хамруулсан.

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

БОЛОВСРУУЛСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА